

**МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИСС**



**МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ИЛТГЭЛ**

2007

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УЛААНБААТАР ХОТ

DDC
323'517
M-692

ГАРЧИГ

ОРШИЛ	4
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	
ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧДЫН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	5
Дүрмийн бус харьцаа, түүний үр дагавар	6
Цэргийн албан хаагчдад оногдуулж буй сахилгын шийтгэлийн талаар	8
Цэргийн албан хаагчдын орон байр, ахуй нөхцөл	11
Цэргийн албан хаагчдын хоол хүнс, хувцасны хангалт	13
Эмнэлгийн үйлчилгээ, эм бүтээгдэхүүний хангалт	15
Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хамгааллын асуудал	17
Цэргийн байгууллагад ажиллаж буй энгийн ажиллагсдын хөдөлмөрлөх эрх	18
ХОЁРДУГААР БҮЛЭГ	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ	
Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах эрх зүйн орчин	20
Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх статистик	32
Алагчлалаас ангид байх эрхийн хэрэгжилт	34
Нийгмийн халамж, хамгаалал хүртэх эрхийн хэрэгжилт	39

ISBN: 99929-78-39-2

Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийн хэрэгжилт	43
Сурч боловсрох эрхийн хэрэгжилт	48
Хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт	51
Сэтгэцийн өвчтэй хүмүүсийн эрхийн хэрэгжилт	55

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хүний эрхийн боловсролын талаарх дэлхий нийтийн чиг хандлага	59
---	----

Хүний эрхийн боловсролын талаарх Монгол Улсын хууль тогтоомж, төрийн бодлого	61
---	----

Хүний эрхийн боловсролын хэрэгцээ, шаардлага	62
--	----

Албан боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсрол	63
---	----

Албан бус боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсрол	68
---	----

САНАЛ, ЗӨВЛӨМЖ	70
--------------------------	----



ОРШИЛ

Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар Улсын Их Хуралд илтгэж байна.

ХЭҮК-ын ээлжит зургаа дахь илтгэл нь цэргийн албан хаагчдын, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн хэрэгжилт болон хүний эрхийн боловсрол зэрэг сэдвийн хүрээнд бичигдэв.

Энэхүү илтгэлийг Хүний Эрхийн Үндэсний Комисс нь өөрийн болон бусад нэр хүнд бүхий байгууллагуудын судалгаа, хяналт шалгалтын дүнг үндэслэн боловсруулсан болно.

Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлд зэвсэгт хүчин иргэний хяналтанд байх тухай заасан боловч цэргийн албан хаагчдын эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн төлөв байдал өнөөг хүртэл хөндлөнгийн хяналт шалгалтаас гадуур, хаалттай байж ирсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэгш боломж олгох, тэдэнд ээлтэй орчин бүрдүүлэхэд дэлхий нийт ихээхэн анхаарал хандуулах боллоо. Үүний илрэл нь 2006 оны 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын конвенцийг батлан гаргасан явдал юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрх, эрх чөлөөгөө бүрэн дүүрэн эдлэх нөхцөл бололцоо, орчинг бий болгох талаар эрх зүйн зохицуулалт хангалтгүй, хууль тогтоомжийн хэрэгжүүлэх нөөц бололцоо хязгаарлагдмал, хөгжлийн бэрхшээлийн асуудалд хандах хүний эрхийн хандлага төлөвшөөгүйгээс тэдгээр иргэдийн эрх, эрх чөлөө ноцтой зөрчигдөж байна. Энэхүү илтгэлд Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвд хэвтэж эмчлүүлж буй өвчтөнүүдийн эрхийн асуудлыг тусгайлан авч үзсэн болно.

Хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх нь ардчилсан ёс, тэгш байдал хангагдах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо нэмэгдэх нөхцлийг бий болгодог төдийгүй иргэн бүрийг эрх, эрх чөлөө, үүрэг, хариуцлагынхаа талаар мэдлэгтэй, зөрчигдсөн эрхээ хамгаалах чадвартай, бусдын эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх хандлагыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой юм. 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу албан ба албан бус боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсрол олгох хөтөлбөр хэрэгжиж эхлээд 15 жил өнгөрч байгаа хэдий ч үр дүн муутай, бүх нийтийг хамарч чадахгүй байна.

Иймд дээрх асуудалд анхаарал хандуулан, өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, хүндрэл бэрхшээлийг арилгах, хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн санал, зөвлөмж өгөхийг Хүний Эрхийн Үндэсний Комисс зорьж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧДЫН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол Улс ардчилал, зах зээлийн нийгмийг байгуулах сонголт хийснээс хойш батлан хамгаалах салбарт олон чухал өөрчлөлт гарч, энэ харилцааг зохицуулж байсан хууль тогтоомж үндсэндээ шинэчлэгджээ. Монгол Улсад цэргийн албан хаагчийн эрх зүйн байдал, цэргийн албан үүрэгтэй холбоотой харилцааг Үндсэн хууль (1992), Батлан хамгаалах тухай (1993), Зэвсэгт хүчний тухай (2002), Хилийн тухай (1993), Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай (1992), Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай (1994), Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай (2002), Төрийн албаны тухай (2002) зэрэг хууль тогтоомж болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Батлан Хамгаалахын сайд, Хууль Зүй, Дотоод Хэргийн сайд, Зэвсэгт Хүчний Жанжин Штаб, Хил Хамгаалах Ерөнхий Газрын даргын тушаалаар батлагдсан дүрэм, журмуудаар зохицуулж байна. Батлан хамгаалах салбарт нийт 20 гаруй хууль, 60 орчим дүрэм, журам үйлчилж байна.

2006 онд Хүний Эрхийн Үндэсний Комиссоос Зэвсэгт Хүчний Жанжин Штабын харьяа Улаанбаатар цэргийн хүрээний 6 анги, Хил Хамгаалах Ерөнхий Газрын харьяа Дорноговь, Увс аймгийн хилийн цэргийн 5 анги, тэдгээрийн харьяа застав, харуулуудыг хамруулан шалгалт зохион байгууллаа. Тус шалгалтын хүрээнд цэргийн албан хаагчдын хуульд заасан эрхийн хэрэгжилт, цэргийн байгууллага дахь хүний эрхийн зөрчлүүд, тэр дундаа дүрмийн бус харьцаанаас үүдэн гарч буй үр дагаврууд, цэргийн байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажиллагсдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт, цэргийн албан хаагчдын амьдрах орчин, ахуй нөхцөл, хоол хүнс, хувцасны хангалт, хөдөлмөр хамгааллын байдалд үнэлэлт дүгнэлт өгөв.

Дүрмийн бус харьцаа, түүний үр дагавар

1. Цэргийн албан хаагчид нь албан тушаалын зэрэглэл, цолны эрэмбээр захирах, захирагдах ёсыг чанд сахиж, албан үүргээ гүйцэтгэдэг онцлогтой. Гэвч энэхүү онцлог харилцааг хэрэгжүүлэх явцад цэргийн албан хаагчидтай дүрмийн бус харьцах, дэглэх, хүч хэрэглэх, нэр төрийг нь гутаан доромжлох зөрчил дутагдал гарч байна. Хүний эрхийн ийм зөрчлийг ямар ч тохиолдолд нуун далдалж, өөгшүүлэн дэмжиж, захирах, захирагдах ёсны үзэл санааны дор цагаатгаж болохгүй бөгөөд цэргийн албаны онцлог, нарийн харилцаанд хүний эрхийн үндсэн зарчим, хэм хэмжээ чанд мөрдөгдөх ёстой.

2. Шалгалтанд хамрагдсан Зэвсэгт хүчний ангиудад алба хааж буй 829 хугацаат цэргийн албан хаагчдаас авсан санал асуулгаар 79.4 хувь нь түрүүч нар, 55.9 хувь нь офицерууд, 53.6 хувь нь ахлагч нар, 38.7 хувь нь байлдагч нар дүрмийн бусаар харьцдаг гэж хариулсан байна. Хилийн цэргийн ангиудын 522 хугацаат цэргийн албан хаагчид санал асуулгад хамрагдсанаас 44.8 хувь нь ахлагч нар, 23.0 хувь нь офицерууд, 10.2 хувь нь түрүүч нар, 22.0 хувь нь байлдагч нар дүрмийн бус харьцдаг гэжээ. Зэвсэгт хүчний цэргийн ангиудын санал асуулгад хамрагдагсдын 32.3 хувь нь зодож, хүч хэрэглэдэг, 33.5 хувь нь айлган сүрдүүлж дарамталдаг, 36.6 хувь нь мөнгө, эд зүйл шаарддаг, Хилийн цэргийн ангиудад 17.6 хувь нь зодож хүч хэрэглэдэг, 17.6 хувь нь айлган сүрдүүлж дарамталдаг, 6.3 хувь нь мөнгө, эд зүйл шаарддаг гэж тус тус хариулсан байна. Зэвсэгт Хүчний Клиникийн Төв Госпитальд 2006 оны эхний 10 сард хэвтэж эмчлүүлсэн хугацаат цэргийн албан хаагчдаас дээд албан тушаалтандаа зодуулж, эмнэлэгт хэвтсэн 12 байлдагч байна. Эдгээр тоо баримтаас харахад цэргийн албан хаагчдыг зодох, дарамтлах, айлган сүрдүүлэх зэргээр хууль, дүрмийн бус хүрээнд харьцах зөрчил багагүй байна гэж үзэх үндэслэлтэй байна.

3. Радио холбооны станцаар цахилгаанд цохиулах, цээжин дээр буу цэнэглэх, хугацаа зааж “биелэгдэх боломжгүй” даалгавар өгөх, элэгдэх, бакалдах, шанаадах зэргээр цэргийн

албан хаагчдыг “дэглэдэг” бөгөөд энэ тухай мэдээлэл ангийн удирдлагад тэр бүр хүрч чадахгүй, далд, нууц оршиж байна. Шалгалт, судалгаанд хамрагдсан ангиуд төдийгүй батлан хамгаалах салбарын удирдах албан тушаалтнууд дүрмийн бус харьцаатай холбоотой зөрчил бараг гардаггүй гэж байгаа нь нэг талаас ийм зөрчил “далд” хэлбэртэй байдаг, нөгөө талаас эдгээрийг илрүүлэх, арилгах арга хэмжээг хангалттай зохион байгуулдаггүйтэй холбоотой байна. Шалгалтын үеэр бусдад зодуулж, эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байгаа хэд хэдэн цэрэгтэй ярилцахад хэнд зодуулсан тухайгаа хэлэхийг хүсэхгүй байлаа. Ийм зөрчлийн талаар өргөдөл, гомдол гаргасан цэргийн албан хаагч илүү их дарамтанд өртдөг, түүнийг хамгаалах арга хэмжээ авдаггүйгээс цэргийн албан хаагчид эрхээ хамгаалах боломжгүй байна. Энэ нь “Армид ольсон цэрэг, оргосон цэрэг сайнаа үздэггүй” гэсэн зарчим үйлчилдэгтэй холбоотой гэж цэргийн албан хаагчид ярьж байна.

4. Даамжирч ужгирсан дүрмийн бус харьцаа нь цэргийн байгууллагад эрүүгийн гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцлийг бүрдүүлж байна. Дүрмийн бус харьцаанаас үүдэлтэй зарим ноцтой гэмт хэрэг хилийн цэргийн ангиудад гарч байжээ. Тухайлбал, 2005 оны 5 дугаар сард Хилийн цэргийн 0245 дугаар ангийн Уулын харуул дээр байлдагч “А, Э, О” нар заставын орлогч, харуулын даргаа буудаж, амь насыг нь хохироогоод ОХУ-ын хилийг давж зугтан гарсан, мөн оны 11 дүгээр сард тус ангийн Боголтын харуул дээр харуулын ахлагч нь байлдагчаа зодсоноос болж байлдагч “Э” харуулын дарга, түүний эхнэр, хамт байсан байлдагч нарыг буудсаны улмаас харуулын дарга нас барж, бусад нь хүнд гэмтэж, хөдөлмөрийн чадвараа алдсан байна. 2006 оны 1 дүгээр сард тус ангийн харуулын дарга “А”, холбоочин “Б” нар маргалдаж, улмаар “Б” нь “А”-гийн толгойн тус газар модоор цохин, амь насыг нь хохироосон ноцтой хэрэг гарчээ. 2005 онд Нийслэлийн дүүргүүдийн шүүхээр Улаанбаатар цэргийн хүрээний анги нэгтгэлүүдээс Эрүүгийн хуулийн 277 дугаар зүйлийн захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх гэмт хэрэгт 3 цэргийн албан хаагч ял шийтгүүлсэн байна. 2005-2006 онд Эрүүгийн хуулийн

278 дугаар зүйлийн бие биедээ захирагдахгүй цэргийн албан хаагчид дүрмийн заалт зөрчсөн гэмт хэрэгт 23 цэргийн албан хаагч ял шийтгүүлсэн дүн мэдээ гарчээ¹.

5. Эргэлт уулзалт авсан, чөлөөгөөр гарч ирсэн цэргүүдээс ямар нэгэн татаас авах, нэгжлэг хийх, эд зүйлийг хураах зөрчил гарч байна. Түүнчлэн, цэргийн албан хаагчдад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас буюу шагнал, сайшаалын журмаар олгогдох ёстой цэргийн чөлөөний хуудсыг худалдах тохиолдол гарч байна. Тухайлбал, Зэвсэгт хүчний 029, 013, 120, 326 дугаар ангиудад мөнгө, эд зүйл нэхэх, шаардах, 032 дугаар ангийн зарим албан тушаалтан чөлөөний хуудсыг нууцаар худалдаж байсан нь шалгалтын явцад тогтоогдсон.

6. Офицер, ахлагчид хугацаат цэргийн албан хаагчдаар өөрийн болон найз нөхөд, танил талынхаа мод түлээ бэлтгэх, шавар, шохой зөөх, барилга барих, нүх ухах, суваг шуудуу татах зэрэг “хар бор” ажлуудыг хийлгэж байгаа нь албадан хөдөлмөрийн шинжийг агуулж байна. Дээрх ажлуудыг хийлгэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангадаггүй, хамгаалах хувцас, хэрэгсэл олгодоггүйгээс цэргүүд бэртэж, гэмтэж байна. Шалгалтанд хамрагдсан Зэвсэгт хүчний ангиудын цэргийн албан хаагчдын 57.8 хувь нь тушаалын дагуу “хар бор” ажил хийдэг гэж санал асуулгын хуудсанд тэмдэглэсэн байна. Иймд цэргийн албан хаагчдаар хувийн ажил хийлгэж байгаа явдлыг нэн даруй таслан зогсоох шаардлагатай байна.

Цэргийн албан хаагчдад оногдуулж буй сахилгын шийтгэлийн талаар

7. Цэргийн албан хаагчдад оногдуулах сахилгын шийтгэлийн хэлбэрүүд, тэдгээрийг оногдуулахтай холбогдсон харилцааг “Цэргийн сахилгын дүрэм”²-ээр зохицуулж байна. Уг дүрэмд түрүүч, байлдагч болон офицер, ахлагч нарт оногдуулах сахилгын шийтгэлийн хэлбэрүүдийг ялгаатай тогтоожээ. Өөрөөр хэлбэл, уг дүрэмд заасны дагуу цэргийн

¹ Нийслэлийн шүүхийн статистик мэдээнээс

² Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 216 дугаар зарлигийн хавсралт

дүрэм, анги, байгууллагын дотоод дэг журам зөрчсөн түрүүч, байлдагчдад сануулах, түр чөлөөг хасах, албан тушаал бууруулах, 10 хүртэл хоног тусгаарлан саатуулах гэсэн 4 төрлийн сахилгын шийтгэл оногдуулж байна. Харин офицер, ахлагч нарыг тусгаарлан саатуулахгүйгээр бусад хэлбэрийн сахилгын шийтгэлийг оногдуулж байх тухай заажээ. Нэг төрлийн сахилгын шийтгэлийг давхардуулах, цэргийн албан хаагчийн хувийн нэр хүндийг гутаах, ширүүн догшин харилцах, бүдүүлэг зан авир гаргах, хамт олноор нь залхаахыг хатуу хориглосон байна. Улаанбаатар цэргийн хүрээний бүх ангиудын тусгаарлан саатуулах сахилгын шийтгэл хүлээсэн цэргийн албан хаагчдыг Зэвсэгт хүчний 032 дугаар ангид байрлах сахилгын хорих байранд тусгаарлан саатуулж байна.

8. Тусгаарлан саатуулах шийтгэлийг сахилгын хорих байранд эдлүүлэх бөгөөд сахилгын хорих байр нь цэргийн хүрээний буюу цэргийн ангийн харьяалалд байж болох тухай “Цэргийн харуулын ба хүрээний албаны дүрэм”³-д тусгасан байна. Түүнчлэн, уг дүрэмд “Сахилгын хорих байр нь ганцаарчлан болон нийтээр нь хорих зориулалттай 2 төрлийн өрөөтэй, унтаж амрахад зориулсан модон наартай байх, өрөөний дулаан 18 градусаас доош байгаа тохиолдолд саатуулагдсан этгээдэд шинель өгч болно” гэж заасан байдаг. Цэргийн албан хаагчдыг тусгаарлан саатуулах сахилгын хорих байрны нөхцлийн энэ стандарт нь Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдын 2002 оны 270 дугаар тушаалаар батлагдсан хорих ангид тогтоосон дэглэм журам зөрчиж, сахилгын арга хэмжээ авагдсан ялтныг тусгаарлан хорих “Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл журам”-д зааснаас доогуур байна. Тухайлбал, дээрх заалтыг тусгаарлан саатуулагдаж буй цэргийн албан хаагчид хөнжил, гудас тавьж өгөхгүйгээр зөвхөн модон нааран дээр унтуулж болох төдийгүй өрөөний дулаан 18 градусаас доош байж болох мэтээр ойлгож, хэрэглэх боломжтой байна.

9. Эрүүгийн хуулийн 51 дүгээр зүйлийн 51.4-т “Цэргийн жинхэнэ хугацаат албан хаагчид оногдуулсан баривчлах ялыг

³ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 216 дугаар зарлигийн хавсралт

сахилгын байранд ганцаарчлан эдлүүлнэ” гэж заасан. Энэ заалтын дагуу баривчлах ялтай цэргийн албан хаагч нь ялаа цэргийн хүрээний буюу цэргийн ангийн харьяаны сахилгын байранд эдлэх ёстой болж байна. Гэтэл “Цэргийн харуулын ба хүрээний албаны дүрэм”-ээр тодорхойлсон сахилгын байрны нөхцөл, журам нь Хууль Зүй Дотоод Хэргийн сайдын өмнө дурдсан тушаалаар батлагдсан сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, журамд нийцэхгүйгээр үл барам байдлыг дордуулсан шинжтэй байгааг анхаарах шаардлагатай байна. Дүрэм, журам, нөхцөл байдлын ийм ялгаатай байдал нь цэргийн хүрээ, ангийн сахилгын хорих байрны стандартын талаар чухам ямар дүрэм, журам үйлчлэх ёстойг тодорхойгүй болгож байна.

10. Цэргийн харуулын ба хүрээний албаны дүрэмд “цэргийн албан хаагчдыг хорих зөвшөөрлийг харьяалах прокурорын байгууллагаас авна, цэргийн хүрээ, ангийн сахилгын хорих байрыг холбогдох байгууллагын зөвшөөрлийг үндэслэн хүрээний даргын тушаалаар ажиллуулна” гэж заажээ. Дүрэмд заасан “холбогдох байгууллага” гэдгийг прокурорын байгууллага гэж ойлгож болох юм. Үүнээс үзэхэд, сахилгын хорих байр ажиллуулах, цэргийн албан хаагчийг тусгаарлан саатуулах бүрт прокурорын зөвшөөрөл авах ёстой байна. Гэвч энэ заалт бодит байдал дээр огт хэрэгжихгүй байна.

11. Тусгаарлан саатуулах шийтгэлийг оногдуулах эрх бүхий субъектыг цэргийн сахилгын дүрмээр тогтоосон байдал анхаарал татаж байна. Тусгаарлан саатуулах шийтгэл нь түрүүч, байлдагч нарын халдашгүй эрхийг хязгаарласан, хүнд хэлбэрийн шийтгэл мөн боловч ийм шийтгэлийг 10 шахам албан тушаалтан оногдуулж болохоор заажээ. Тусгаарлан саатуулах шийтгэл оногдуулж болох албан тушаалтнуудын дотор төмөр замын өртөө, нисэх буудлын зохицуулагч, аймаг, нийслэлийн цэрэг, иргэний хамгаалалтын штабын ажилтнууд хүртэл орж байгаа нь цэргийн албан хаагчийн эрхэнд нэн бүдүүлгээр халдаж болох нөхцлийг бүрдүүлж байна.

12. Сахилгын хорих байранд саатуулагдаж байгаа цэргийн албан хаагчдын бүртгэлийг хөтлөх, хүлээн авах

хуудсанд шийтгэлийн үндэслэл, шийтгэл оногдуулсан албан тушаалтны нэр, цол зэргийг тодорхой тусгах тухай дүрмийн заалт бүрэн биелэгдэхгүй байна. Тухайлбал, Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн сахилгын хорих байрны бүртгэлийг судлахад мэдээлэл дутуу, шийтгэл оногдуулсан тушаал, шийдвэрийг хавсаргаагүй, зарим тохиолдолд саатуулагсдын бүртгэл огт хөтлөгдөөгүй байна. Тусгаарлан саатуулах шийтгэлийг 10 хүртэл хоногоор оногдуулах ёстой боловч зөвшөөрөгдсөн хугацаанаас хэтрүүлэх явдал түгээмэл гарч байна. Тухайлбал, ротын захирагч түрүүчийг 3, байлдагчийг 5 хүртэл хоногоор тусгаарлан саатуулж болохоор дүрэмд заасан байхад Зэвсэгт хүчний 029 дүгээр ангийн ротын захирагч байлдагчдад ихэнх тохиолдолд 5-аас дээш хоног тусгаарлах шийтгэл оногдуулж, өөрт олгогдсон эрх мэдлээ хэтрүүлж байсан байна.

13. Сахилгын хорих байранд саатуулагдсан цэргийн албан хаагчдыг өдөрт 2 удаа, зарим үед 1 удаа хооллож, гоожуурын түүхий ус уулгадаг, салхилуулдаггүй, хучлага өгдөггүй, модон нааран дээр унтуулдаг, их хүйтэн учраас даарч хонодог тухай Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах ангид тусгаарлан саатуулагдсан цэргүүд ярьж байна. Ийм байдал хилийн цэргийн зарим ангид ч давтагдаж байна. Тухайлбал, Хилийн цэргийн 0108 дугаар ангийн сахилгын хорих байр нь ямар ч агааржуулалт, гэрэлтүүлэггүй, цэргийн албан хаагчийг саатуулах нөхцөлгүй байлаа. Иймд Цэргийн сахилгын дүрэм болон Цэргийн харуулын ба хүрээний албаны дүрмийг өөрчилж, тусгаарлан саатуулах шийтгэл оногдуулахтай холбогдсон хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох шаардлагатай байна.

Цэргийн албан хаагчдын орон байр, ахуй нөхцөл

14. Цэргийн дотоод албаны дүрэм (1999), Цэргийн албаныг зохион байгуулах заавар (2001), Хилийн тусгай анги, салбарын цэргийн албаны зохион байгуулалтын заавар (2002) зэрэг баримт бичгээр цэргийн албан хаагчдын орон байрны нөхцлийн стандартыг тогтоожээ. Цэргийн албан хаагчид нь

эрүүл ахуй, аюулгүйн шаардлага хангасан, дээрх заавар, дүрэмд нийцсэн нөхцөлд алба хаах ёстой. Гэвч шалгалтанд хамрагдсан ихэнх ангиудын ахуй нөхцөл стандартад нийцэхгүй байна. Улаанбаатар цэргийн хүрээний ангиудын зарим барилга байшин хуучирч муудсан, хана тааз нь нуралт өгсөн, мөөгөнцөртсөн байна. Тухайлбал, Зэвсэгт хүчний 029 дүгээр ангийн барилгын зарим хэсэг нь 1917 онд ашиглалтанд орсон боловч өнөөг хүртэл засвар үйлчилгээ хийх төдийгөөр тордож, ашигласаар байна. Түүнчлэн, цэргийн ангиудын сантехникийн шугам сүлжээ муудсан, цахилгааны монтаж нь хуучирсан зэрэг бэрхшээл тулгарч байгааг холбогдох байгууллагууд анхааралдаа авах шаардлагатай байна.

15. Цэргийн дотоод албаны дүрмийн 113 дугаар зүйлд “зориулалтын бус байранд хүн байрлуулахыг хориглоно”, Цэргийн албаныг зохион байгуулах зааврын 4-ийн “а”-д “унтлагын байранд хугацаат цэргийн албан хаагчдыг байрлуулахдаа хүн бүрт 2.5-4.0 м² талбай, 9-12 м³-ээс багагүй агаар ноогдохоор тооцно, харин гэрээт цэргийн албан хаагчдыг байрны багтаамж, боллоцгоог тооцон аль болох цөөн хүн байхаар байрлуулна” гэж тус тус заасан байна. Шалгалтанд хамрагдсан зарим ангид эдгээр заалтууд биелэгдэхгүй байна. Тухайлбал, Хилийн цэргийн 0311, Зэвсэгт хүчний 120 дугаар ангиудад ээлжит цэрэг татлагын үеэр хэт жижиг өрөөнд хугацаат цэргийн албан хаагчдыг бөөнөөр байрлуулсан, Хилийн цэргийн 0168, 0245 дугаар ангиуд спортын зааландаа цэргүүдийг байрлуулж байгаа нь дүрэм, журамд нийцэхгүй байна. Хугацаат цэргийн албан хаагчдын байр хүйтэн, гэрэлтүүлэг хангалтгүй, чийгшилт ихтэй байгаа нь шалгалтанд хамрагдсан ангиудад нийтлэг байна.

16. “Цэргийн албаныг зохион байгуулах заавар”-ын 4-ийн “б”-д заасны дагуу амралт соёлжилтын танхим нь ангийн бие бүрэлдэхүүн чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх, алжаал тайлах, тэдний оюуны болон соёлын хэрэгцээг хангахуйц тохилог, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангагдсан байх ёстой боловч зааврын хэрэгжилт хангалтгүй байна. Ялангуяа, Зэвсэгт хүчний ангиудын амралт соёлжилтын танхимын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт, чанар муу, Хилийн

цэргийн ангиудын хувьд сонин сэтгүүл, ном, товхимлын хангалт сайнгүй байгаа нь ажиглагдаж байна. Түүнчлэн, урлаг, спорт, соёл, хүмүүжлийн ажил тогтмол зохион байгуулагдахгүй байгааг цэргийн албан хаагчид шүүмжилж байна. Шалгалтанд хамрагдсан 11 ангийн 5 нь биеийн тамир, спортын зориулалтын заал байхгүй, үлдсэн ангиуд спортын заалтай боловч тохь тух муутай, хүйтэн, эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй байгаа төдийгүй зарим ангиуд спортын заалаа зориулалтын бусаар ашиглагдаас цэргийн албан хаагчдын чөлөөт цагаа үр ашигтай өнгөрүүлэх, бие бялдраа хөгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

17. “Цэргийн дотоод албаны дүрэм”-ийн 184 дүгээр зүйл, “Цэргийн албаныг зохион байгуулах заавар”-ын 11-д заасны дагуу цэргийн анги, байгууллага нь цэргийн алба хаагчид эргэлтээр ирсэн хүмүүстэй уулзах байрыг гаргаж, тохижуулахаар заасан байна. Эргэлт, уулзалтын байрыг дээрх дүрэм, зааврын дагуу тохижуулж, уулзаж буй хүмүүсийн ярианы нууцлал, тохь тухыг хангасан нөхцөл байдлыг бүрдүүлэх нь цэргийн албан хаагчдын эрхийг хангах, ялангуяа, дүрмийн бус харьцааг таслан зогсоход чухал ач холбогдолтой. Гэвч шалгалтанд хамрагдсан Зэвсэгт хүчний ангиуд шалган нэвтрүүлэх байрныхаа нэг хэсгийг эргэлт уулзалтын зориулалтаар ашиглаж байгаа нь цэргийн албан хаагчдын эрхийг хангаж чадахгүй байдалд хүргэж байна. Харин Хилийн цэргийн ангиудын хувьд ангийн зочид буудлыг эргэлт, уулзалтын зорилгоор ашигладаг нь сайшаалтай байна.

Цэргийн албан хаагчдын хоол хүнс, хувцасны хангалт

18. Цэргийн анги байгууллагуудад хоол хүнсний хангалтыг Засгийн газрын хүнсний хангамжийн хэмжээг тогтоох тухай 2003 оны 266 дугаар болон 2006 оны 103 дугаар тогтоолын дагуу бүрэн хийдэггүй, төсөв хөрөнгө хүрэлцэхгүй гэсэн шалтгаанаар чанаргүй хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх тохиолдол байна. Санал асуулгад хамрагдсан цэргийн албан

хаагчид хоолондоо цаддаггүй, хоолыг бохир орчинд бэлтгэдэг, малын гэдэс дотроор хоол хийх нь их, талх түүхий байдаг гэсэн санал, гомдлыг нийтлэг гаргаж байна. Нийт цэргүүдийн 25.6 хувь нь хоол хүнсний хангалт, амт чанарыг дунд буюу муу гэж үнэлсэн байна.

... 2006 оны 7-9 дүгээр саруудад цэргийн хүнсэнд 8-15 кг жинтэй хонь худалдан авсан боловч дарга нарынхаа үүргээр 26 кг-аар орлого авснаас болж, цэргүүдийн хоол, хүнс хүрэлцэхгүй болсон. Намар тэмээний мах тасралтгүй өгснөөс цэргүүд сэрүүдэж, их шээх болсон, өвөл тэр чигтээ цувдай идэж өнгөрөөсөн.

... Хүйтэн сэрүүний улиралд тэмээний мах идэх нь эрс тэс уур амьсгалтай газар зохидоггүй. Адууны цувдай, элэг, уушиг байнга өгч, илжирч муудсан цувдай харуулуудад очдог. Нэгдсэн хангалтаар хүрэлцэхүйц хэмжээний хүнсээр хангаж байгаа гэх боловч нэг ч удаа эрүүл мэндэд нийцсэн хоол хүнс идэж үзсэнгүй. Иддэг хоол ийм байхад хилд үүрэг гүйцэтгэж байгаа цэрэг, харуулын дарга нарын бие болон сэтгэл санаа ямархуу байх вэ дээ...

Цэргийн албан хаагчтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

19. Цэргийн албан хаагчдын хувцас, хэрэглэлийн нормыг Засгийн газрын 1999 оны 16 дугаар тогтоолоор баталжээ. Цэргийн анги байгууллагуудад жилдээ 2 удаа хувцасны хангалт хийж байна. Шалгалтын үеэр хангалтаар ирж байгаа хувцасны чанар муугаас эдэлгээ даахгүй байгаа талаар нэлээд шүүмжлэл гарч байлаа. Тухайлбал, гутлын чанар муугаас чийг татдаг, өглөө, оройд хөл даардаг, хөлийн ороолтын материал муу, амархан урагддаг, хэмжээ бага байдаг гэж цэргийн албан хаагчид ярьж байв. Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн эмнэлэгт хөлөө холгуулж шархалсан, хөл нь өвлийн хүйтэнд хайрагдсан гэх 2 цэрэг хэвтэж, эмчлүүлж байлаа. Цэргийн албан хаагчдын энэ санал, гомдлыг холбогдох байгууллагууд

тендер, нийлүүлэлтийн үйл ажиллагаа зохион байгуулахдаа онцгойлон анхаарч үзэх шаардлагатай байна.

Эмнэлгийн үйлчилгээ, эм бүтээгдэхүүний хангалт

20. Цэргийн ангиудын эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангалт муу, төсөв хүрэлцдэггүй, дутуу орон тоогоор ажилладаг төдийгүй төсвийн санхүүжилт нь зөвхөн хэвтэж эмчлүүлэгсдийн зардлыг нөхөн олгодгоос цэргийн албан хаагчдыг эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлж чаддаггүй байна. Алслагдсан хөдөө орон нутагт нарийн мэргэжлийн эмчийг татаж, ажиллуулах бодлого хангалтгүйн улмаас Хилийн цэргийн ангиуд мэргэжлийн боловсон хүчнээр дутагдаж байна. Энэ нь хилийн цэргийн эмнэлэг зөвхөн ангийн төвд үйл ажиллагаа явуулж застав, харуулуудад тэр бүр хүрч үйлчилж чадахгүйд хүргэж байгаа юм. Заставуудад ариун цэврийн зааварлагчийн орон тоо байгаа хэдий ч энэ орон тоон дээр ихэвчлэн мэргэжлийн бус хүн ажиллаж, өөр ажил хавсран гүйцэтгэж байна. 2006 онд Хилийн цэргийн 0311 дүгээр ангийн заставт 2 байлдагч албан үүргээ биелүүлж яваад бие эрхтэндээ гэмтэл авч, цаг тухайд нь эмнэлгийн тусламж авч чадаагүйгээс амь насаа алдсан тохиолдол анхаарал татаж байна.

УИН.МН
СУДАЛГААНЫ САН

...Хилийн цэргийн 0311 дүгээр ангийн байлдагч Тэгшбаярын Нямхишиг (22 настай) 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр морьтой явж байгаад духаараа мод мөргөж бэртсэн боловч толгойгоо бариулах төдийхнөөр аргацааж, эмнэлгийн тусламж авалгүй 3 хоносон байна. Тухайн үед тус ангийн их эмч Н.Нарангаравыг ээлжийн амралттай байх үед Төрийн Тусгай Албан Хаагчдын Нэгдсэн Эмнэлгийн эмч н.Сэргэлэн 0311 дүгээр ангид ажиллаж байжээ. Өвчтөнийг н.Сэргэлэн эмч үзэж, жор бичсэний дагуу эмийн эмчилгээ хийсэн байна. Байлдагч 7 дугаар сарын 24-нөөс 8 дугаар сарын 5-ны өдрийг хүртэл ангийн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн боловч бие нь сайжраагүй ажээ.

Тэрээр мөн өдрөө Увс аймгийн нэгдсэн эмнэлэгт хүргэгдсэн бөгөөд тэндээ 2 хоноод Улаанбаатар хот руу явсан байна. Т.Нямхишиг нь онгоцонд ухаан алдаж, ТТАХНЭ-г хэвтсэн боловч ухаан орохгүй байсаар нас баржээ. Эмнэлгийн дүгнэлтээр тархиндаа цус харвасан болох нь нотлогдсон байна.

Ангийн эмнэлгийн өвчтөний түүхээс...

21. Цэргийн ангиудад хугацаа нь дууссан эм, тариаг устгал хийлгүй хадгалж, шаардлагатай тохиолдолд хэрэглэж байгаа нь цэргийн албан хаагчдын эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байна. Тухайлбал, шалгалтын үеэр Хилийн цэргийн 0168 дугаар ангийн эмийн санд 1-4 жилээр хугацаа нь хэтэрсэн 27 тариа, 9 төрлийн эм, Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн эмийн санд 1-3 жилээр хугацаа нь хэтэрсэн 15 төрлийн эм, тариа тус тус хадгалагдаж байлаа.

22. Цэрэг татлагын комиссын эрүүл мэндийн үзлэг хангалтгүй явагдаж байгаагаас хугацаат цэргийн албанд суурь болон халдварт өвчтэй залуус татагдан ирж байна. Үүнээс болж бусад цэргийн албан хаагчдад элдэв өвчний халдвар тархаж, эмнэлгийн үйлчилгээг хүндрүүлж байгааг анхаарах шаардлагатай байна. Жишээлбэл, Хилийн цэргийн 0245 дугаар ангид өрөөсөн нүд нь хараагүй байлдагч цэргийн алба хааж байсан, Зэвсэгт хүчний 015 дугаар ангид 2006 онд Эрдэнэт

хотоос “Г” гэгч сүрьеэтэй цэрэг татагдаж ирж, улмаар 3 цэрэгт халдсан тохиолдол гарсан байна.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хамгааллын асуудал

23. “Цэргийн цолны цалингийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 1999 оны 38 дугаар тогтоолоор хугацаат цэргийн албаны байлдагч, түрүүч нь гэрээт цэргийн албан хаагчийн сарын дундаж цалингийн 10 хувьтай тэнцүү хэмжээний цалин хөлс авч байхаар тогтоожээ. Шалгалтын үеэр гэрээт цэргийн албан хаагчид 75000 орчим төгрөгийн цалин авч байхад Зэвсэгт хүчний ангиудын байлдагч 2150 төгрөг, Хилийн цэргийн ангийн байлдагч 4210 төгрөгийн цалин авч байв. Түүнчлэн, цэргийн албан хаагчдын цалин хөлснөөс элдэв төрлийн суутгал хийдэг, сар бүрийн цалингийн цэсэнд гарын үсэг зуруулдаг боловч гарт нь олгодоггүй талаарх гомдлыг цэргийн албан хаагчид гаргаж байлаа. Харин шалгалтын мөрөөр Хүний Эрхийн Үндэсний Комиссоос илгээсэн шаардлагын дагуу 2007 оны 1 дүгээр сараас эхлэн хугацаат цэргийн албаны байлдагчид 8200 төгрөг, түрүүч 10000 төгрөгийн цалин олгож байх тухай Батлан Хамгаалахын сайдын 37 дугаар тушаал гарч, хэрэгжиж эхэлсэн нь сайшаалтай байна. Гэвч цаашид дээр дурдсан цалин хөлстэй холбоотой зөрчлийг гаргахгүй байхад анхаарах шаардлагатай байна.

24. Хилийн цэргийн ангиудын бие бүрэлдэхүүн долоо хоногийн амралт эдлэхгүй, тасралтгүй ажиллаж байгаа боловч ажлын тав хоногийн цалин хөлс авч байгаа нь хүний эрхийг зөрчиж байна. Энэ зөрчил нь ялангуяа, Хилийн цэргийн 0108 дугаар ангийн офицер, ахлагч нарын хувьд анхаарал татаж байна. 2004 оны Монгол-Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хэлэлцээрийн дагуу Эрээн-Замын-Үүдийн хилийн боомт байнгын ажиллагаатай болсны улмаас тус ангийн офицер, ахлагч нар ямар ч ээлж, амралтгүйгээр ажлын 7 хоног, хоногт дунджаар 8-22 цаг ажиллаж байгаа боловч нэмэгдэл

хөлс авахгүй, сарын цалинг нь ажлын 22 өдрөөр тооцон олгож байна. Энэ байдлыг Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль (1992)-ийн 28 дугаар зүйлийн 28.2-т заасан "...хилийн суман, хороонд болон тэдэнтэй адил нөхцөлд байрлаж байгаа офицер, ахлагчийн алба хааж байгаа нэг жилийг нэг жил дөрвөн сард дүйцүүлэн тооцох" тухай хөнгөлөлтөөр цагаатган далдалж болохгүй бөгөөд нэн даруй өөрчлөх шаардлагатай байна.

25. Цэргийн албан хаагчид тушаалын дагуу аль шаардлагатай газар очиж ажилладаг тул үл хөдлөх хөрөнгө олж авах, эзэмших боломж хомс, тэдний гэр бүлийн гишүүд тогтвортой ажил хөдөлмөр эрхэлж, сурч боловсорч чадахгүй байна. Ялангуяа, цэргийн жинхэнэ албан хаагчид бүх насаараа цэргийн байгууллагын байранд амьдарсаар тэтгэвэрт гарахдаа хувийн орон байргүй, 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний олговроос өөр ямар нэг дорвитой тусламж, нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамрагдахгүй байгааг анхаарах шаардлагатай байна. Одоо мөрдөгдөж байгаа цалин хөлсний жишгийн дагуу 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний олговор нь ойролцоогоор 5 сая орчим төгрөг болж байгаа юм. Гэтэл энэ мөнгөөр төвлөрсөн хот, орон газарт сайн хашаа, байшин ч авч чадахгүй нь ойлгомжтой.

Цэргийн байгууллагад ажиллаж буй энгийн ажиллагсдын хөдөлмөрлөх эрх

26. Шалгалтын хүрээнд Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн ангиудад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа 217 ажилтнаас санал асуулга авсан болно. Санал асуулгын дүнгээс цэргийн ангийн удирдлагаас Хөдөлмөрийн тухай хууль болон хөдөлмөрийн гэрээний заалтыг зөрчиж, тэдгээр хүмүүсийн эрх ашгийг хохироож байгаа нь харагдаж байна. Энгийн албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулдаг боловч гэрээний нэг хувийг ажилтанд гардуулдаггүй (санал асуулганд оролцогчдын 25 хувь), тушаалын дагуу байнга илүү цагаар ажиллуулдаг (санал асуулганд оролцогчдын 41.9 хувь), ээлжийн амралтыг

бүрэн эдлүүлдэггүй (санал асуулганд оролцогчдын 11 хувь) ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл олгодоггүй (санал асуулганд оролцогчдын 36.4 хувь), хортой нөхцөлд ажилласан ажилтанд хор саармагжуулах бүтээгдэхүүн олгодоггүй (санал асуулганд оролцогчдын 40 хувь) зэрэг зөрчил, дутагдал гарч байна.

27. Цэргийн байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажилтнууд эрх ашгаа хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэж, үйлдвэрчний эвлэлийн хороодыг байгуулан, улмаар тэдгээр хороодыг нэгтгэсэн холбоог байгуулсан байна. Гэвч эдгээр үйлдвэрчний эвлэлийн байгууллагыг ажиллах нөхцөл бололцоогоор хангахгүй, үйл ажиллагааг нь хязгаарлах, үйлдвэрчний эвлэлийн сонгуультныг хавчиж дарамтлах зэрэг зохисгүй хандлагыг цэргийн байгууллагын удирдлагууд гаргаж байгаа талаар гомдол гарч байна.

...Батлан хамгаалах салбарт ҮЭ-ийн байгууллага 2005 онд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн боловч Зэвсэгт Хүчний Жанжин Штабын зарим албан тушаалтнуудын хууль зөрчсөн ажиллагаа, хавчилт, шахалтаас болж, ҮЭ-ийн ажил зогсонги байдалд орж, ажилчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй байна...

ХЭҮК-т ирүүлсэн гомдлоос, Картын дугаар 2007/29

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах эрх зүйн орчин

1. Хүн бүр яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, язгуур угсаа, бусад ялгааг эс харгалзан хүний эрх, эрх чөлөөг алагчлалгүйгээр эдлэх нь хүний эрхийн үндсэн зарчим мөн. Энэхүү эрх, эрх чөлөө нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактууд болон НҮБ-ын хүний эрхийн талаарх бусад гэрээ, конвенциор баталгаажсан. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “хүн бүр хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй, өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хөгжлийн бэрхшээлтэй болох зэрэг тохиолдолд төрөөс эд мөнгөний тусламж авах эрхтэй” хэмээн заажээ.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах зорилгоор НҮБ-аас Оюуны хомсдолтой хүний эрхийн тухай (1971), Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай (1975), Харааны болон сонсголын бэрхшээлтэй хүний эрхийн тухай (1979) зэрэг тунхаглалуудыг батлан гаргасан байна. Эдгээр тунхаглалуудын зорилго нь аливаа хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр бусдын нэгэн адил хүний эрх, эрх чөлөөг ямар ч ялгаваргүй эдлэх явдлыг баталгаажуулахад оршиж байна.

3. Монгол Улс 1969 онд Хөдөлмөр эрхлэлтэд алагчлахгүй байх тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 111 дүгээр конвенцийг⁴ соёрхон баталсан бөгөөд конвенцид заасны дагуу ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлттэй холбогдсон аливаа алагчлалыг бүрмөсөн устгах үүднээс хөдөлмөр

⁴ Монгол Улс 1969.05.10-нд соёрхон баталсан.

эрхлэлтийн салбарт тэгш боломж олгохыг дэмжсэн үндэсний бодлогыг өөрийн улсын нөхцөл байдал, дадалд тохирсон аргаар тодорхойлж, хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн байна. Түүнчлэн, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэргэжлийн нөхөн сэргээлт ба тэдний хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дүгээр конвенцид⁵ “улс орнуудын төр, засгийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт ба хөдөлмөр эрхлэлтийн талаар үндэсний бодлого боловсруулан хэрэгжүүлж, түүнийгээ тухай бүр эргэн харж, засан сайжруулах үүрэгтэй” болохыг тусгажээ.

4. 2006 оны 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 61 дэх удаагийн Чуулганы хуралдаанаас Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай олон улсын конвенцийг баталсан. Конвенци хүчин төгөлдөр болсноор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хамгаалах улс орнуудын дотоодын механизм боловсронгуй болж, олон улсын эрх зүйд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах шинэ хамгаалалт, тогтолцоо бий болох юм. Ерөнхий Ассамблейн А/61/611 дугаар тогтоолын дагуу тус конвенцид улс орнууд гарын үсэг зурах хугацаа 2007 оны 3 дугаар сарын 30-ны өдөр нээгдсэнээс хойш 4 дүгээр сарын 2-ны байдлаар 81 улс гарын үсэг зурж, 1 улс соёрхон батлахаа мэдэгдээд байна.

5. Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна, хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдлаар ... ялгаварлан гадуурхаж үл болно”, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт “Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй” гэж тус тус заажээ.

6. Монгол Улсын нэгдэн орсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах талаарх олон улсын гэрээ, конвенци, Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэх зорилгоор манай

⁵ Монгол Улс 1998.02.03-нд соёрхон баталсан.

улсад одоогийн байдлаар 35 орчим хууль тогтоомж, 20 гаруй үндэсний болон салбарын хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрх, эрх чөлөөгөө эдлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох ажилд тодорхой ахиц гарч байна. Тухайлбал, 2006 оны 12 дугаар сард Боловсролын тухай хуульд иргэнийг сурч боловсроход хөгжлийн онцлог, эрүүл мэндээр нь ялгаварлан гадуурхахгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамран сургах нөхцөл бололцоог бүрдүүлэх талаар төр тодорхой үүрэг хүлээх тухай нэмэлт өөрчлөлт оруулсан нь чухал арга хэмжээ болжээ. Засгийн газрын 2006 оны 283 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрүүдийг тус тус баталжээ. 2006 оноос 2012 оныг хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжих эдгээр хөтөлбөрүүд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрх, эрх чөлөөгөө эдлэхэд нь тулгамдаад байгаа нэн чухал асуудлуудыг шийдвэрлэх зорилтуудыг дэвшүүлэн тавьснаараа ач холбогдолтой байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Эрүүл мэндийн тухай, Хөдөлмөрийн тухай, Биеийн тамир, спортын тухай, Барилгын тухай, Авто замын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Аж ахуйн нэгж, байгууллагын албан татварын тухай зэрэг 11 хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэгш боломж олгох, саад хязгаарлалтыг арилгах, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, татварын таатай орчин бий болгоход хувь нэмрээ оруулах юм. Түүнчлэн, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамнаас нийгмийн даатгалын багц хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, зохих журмын дагуу холбогдох байгууллагад хүргүүлэх арга хэмжээ аваад байна.

8. Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн суурь үйлчилгээг хүргэхэд чиглэгдсэн эрх зүйн орчин үндсэндээ бүрдсэн гэж үзэж болох хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хүндрэл бэрхшээл учруулахуйц, тэднийг ялгаварлан гадуурхсан шинжтэй хуулийн

зүйл, заалт байгааг өөрчлөх зайлшгүй шаардлагатай байна. Хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалахад чиглэгдсэн олон тооны хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрүүд байгаа боловч тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүжилтийг тодорхой шийдвэрлэхгүй орхигдуулсан, хэрэгжүүлэх байгууллага, механизмыг оновчтой тогтоож чадаагүйн улмаас хууль тогтоомж, хөтөлбөрүүд зөвхөн “цаасан дээр” үлдэж, зориулагдсан хүндээ хүрч үр дүнгээ өгөхгүй байгааг холбогдох байгууллагууд анхааралдаа авах шаардлагатай байна.

9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадвар нь алдагдсан, түүнчлэн, бие эрхтэн нь гэмтсэнээс хөдөлмөрлөх, бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж ойлгоно” гэжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх дээрх тодорхойлолт хэт ерөнхий учраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик мэдээг үнэн зөв гаргах, тэдгээр хүмүүст нийгмийн хамгааллын үйлчилгээг адил хүртээмжтэй хүргэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.

10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн нийгмийн хамгааллын харилцааг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай (2005), Нийгмийн халамжийн тухай (2005), Нийгмийн даатгалын тухай (1994), Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж, төлбөрийн тухай хууль (1994) болон холбогдох бусад дүрэм, журмаар зохицуулдаг. Хууль тогтоомжид зааснаар нийгмийн хамгааллын тогтолцоо нь нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн тогтолцоо гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд нийгмийн халамжийн үйлчилгээг хүртэгсдийн дунд харьцангуй тогтвортой бүлгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна. 2005 онд батлагдсан Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т “бүрэн хараагүй, хэлгүй, дүлий, одой иргэн”, 18.1.4-т “энэ хуулийн 18.1.3-т зааснаас бусад хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан, бие даан амьдрах чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй иргэн” нийгмийн

даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр авах эрх үүсээгүй бол нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрхтэй гэж хуульчилсан байна. Гэтэл Эрүүл Мэнд, Нийгмийн Хамгааллын сайдын 1997 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан “Ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчин, гэмтлийн жагсаалт”-д хөнгөн хэлбэрийн оюуны хомсдолтой, уналтын улмаас мэргэжлийн ажлаа хийх боломжгүй, нэг нүд сохор, хоёр хөл болон хоёр гар шуу, шилбэний тайралттай зэрэг хүмүүсийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг 70-аас доош байхаар тогтоосон байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөр эрхлэх таатай орчин бүрдэж чадаагүй байгаа өнөөгийн нөхцөлд зөвхөн хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан тохиолдолд нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрх үүсч байгаа нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, Үндсэн хуультай зөрчилдөж байгаа төдийгүй иргэдийн эд мөнгөний тусламж авах эрх хангагдахгүйд хүргэж байна. Хөдөлмөр эрхлэх болон эд мөнгөний тусламж авах боломжгүй байгаагаас олон мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд амьжиргаагаа залгуулах орлогогүй байдалд хүрч, туйлын ядуу амьдарч байна.

11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлд нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн төрлийг тусгасан байна. Тухайлбал, тус зүйлд хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй, нэн ядуу амьдралтай өрхөд орон сууцны хөлс төлөх, түлээ нүүрс худалдан авахад жилд нэг удаа мөнгөн тусламж үзүүлэх, нэн ядуу амьдралтай өрхийн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэн дотоодын рашаан сувилалд сувилуулбал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа олгох, нэн ядуу амьдралтай өрхийн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэний 4 хүртэлх насны нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны төлбөрт хөнгөлөлт үзүүлэх тухай тус тус заасан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд заасан тусламж, хөнгөлөлтийн ихэнх хэсэг зөвхөн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, нэн ядуу амьдралтай иргэдэд л хамааралтай байна.

Эрүүл мэндийн хувьд зохих түвшинд хөдөлмөрлөж чадахгүй болсон, өрх гэртээ дэмжлэг үзүүлэх боломж нь хязгаарлагдсан иргэн бага боловч хөнгөлөлт эдлэхэд нь ийнхүү өндөр шалгуур тогтоож буй нь оновчгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхсан шинжтэй байна.

12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиар тогтоосон тусламж, хөнгөлөлтийн төрлүүд нь биелэгдэх бололцоогүй, амьдралаас хэт тасархай байдалтай байна. Жишээлбэл, тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8-д ядуу амьдралтай, хөдөлмөрийн чадвартай гишүүнгүй, насанд хүрсэн, бүрэн хараагүй иргэнтэй өрхийн суурин телефон утасны төлбөрт хөнгөлөлт үзүүлэхээр тусгажээ. Энэ заалт нь нэг талаас хараагүй хүний нэн шаардлагатай хэрэгцээг олж харсан мэт боловч шалгуур нөхцөл нь дэндүү өндөр босготой байна. Амьжиргааны түвшинг тодорхойлох шалгуур үзүүлэлтийн дагуу дээд болон мэргэжлийн сургууль төгссөн буюу хувьдаа орон байртай иргэнийг ядуу гэж үзэхгүй. Түүнчлэн, ядууд тооцогдох айл тэр бүр суурин утсыг тавиулах боломжгүй, нөгөө талаас хараагүй хүнийг ямагт гэр бүлийнх нь хөдөлмөрийн чадвартай гишүүн асрах шаардлагатай болдог тул ядуу амьдралтай, хөдөлмөрийн чадвартай гишүүнгүй, суурин утастай хараагүй иргэд хэр олон байж энэ тусламж, хөнгөлөлтийг эдэлж чадаж буй нь эргэлзээ төрүүлж байна. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6-д дурдсан нэн ядуу амьдралтай өрхийн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэн дотоодын рашаан сувилалд сувилуулбал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа олгох, 5.1.7-д заасан нэн ядуу амьдралтай өрхийн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэний 4 хүртэлх насны нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны төлбөрт хөнгөлөлт үзүүлэх тухай заалтуудыг ч мөн дурдаж болно. Нэн ядуу амьдралтай хөгжлийн бэрхшээлтэй иргэн рашаан сувилалд сувилуулах, хүүхдээ цэцэрлэгт өгөх, суурин утас тавиулах нь маш хязгаарлагдмал байдаг нь илэрхий билээ.

13. Эрүүл Мэнд, Нийгмийн Хамгааллын сайдын хамтарсан 1997 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан “Ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний жагсаалт”-

ыг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна. Сүүлийн жилүүдэд бруцеллёз зэрэг зарим өвчнийг мэргэжлээс шалтгаалах өвчний жагсаалтаас хассан нь олон арван хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн даатгалын сангаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр тэтгэмж авах, хиймэл эрхтэн, сэргээн засах эмчилгээ хийлгэх, рашаан сувилалд эмчлүүлэхэд үзүүлэх хөнгөлөлтөөс хасагдах нөхцлийг бий болгосон байна. ОХУ, ХБНГУ зэрэг дэлхийн бусад улс орнуудад бруцеллёз өвчнийг мал, аж ахуй болон мал, амьтны гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулах салбарт ажиллагсдын хувьд мэргэжлээс шалтгаалсан өвчин гэж үздэг нийтлэг практик байдгийг бид хүлээж авах нь зүйтэй байна.

14. Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу зөвхөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан иргэн тэтгэвэр, тэтгэмж авах, хөнгөлөлт эдлэх эрхтэй гэж заасан байдаг. Харин ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан хүн нийгмийн даатгалын шимтгэлийг төлж байсан эсэхээс үл хамааран энэ төрлийн хөнгөлөлт, тусламжид хамрагдах бололцоогүй байна.

15. Жил тутам байгууллага, аж ахуйн нэгжийн буруутай үйл ажиллагааны улмаас олон арван иргэд үйлдвэрлэлийн осолд өртөж, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчилж, улмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эгнээнд шилжин, нийгмийн халамж үйлчилгээний ачааллыг нэмэгдүүлсээр байна. Гэтэл хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг биелүүлээгүй байгууллагад хүлээлгэх захиргааны хариуцлагын тогтолцоо боловсронгуй бус байгаагаас иргэдийн эрх ашиг ихээхэн хохироход хүрч байна. Ялангуяа, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлд зааснаар үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 71-ээс дээш хувиар алдсан ажилтанд 18 сарын дундаж цалингийн хэмжээний нөхөн төлбөрийг 1 ба түүнээс дээш удаа, нас барсан бол 36 ба түүнээс дээш сарын цалинтай тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг 1 ба түүнээс дээш удаа

олгоно гэсэн заалтын талаар иргэдээс ихээхэн гомдол, санал ирж байна. Идэр залуу, хийж бүтээх насандаа хөдөлмөрийн чадвараа дахин сэргэхгүйгээр бүрэн алдаж, зөвхөн тэтгэвэр, тэтгэмжийн орлогоор амьдрах болж байгаа иргэнд 18 сарын цалингийн хэмжээний нөхөн төлбөр олгож байгаа нь дэндүү хангалтгүй байна. Хуульд нөхөн төлбөрийг 1 ба түүнээс дээш удаа олгоно гэж заасан тул хариуцлага хүлээх байгууллага дурдсан төлбөрийг хэзээ ч нэгээс дээш удаа олгохгүй нь хэнд ч ойлгомжтой, хохирогчид заргалдаад ч нэмрийг эс олж байна.

16. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдахтай холбогдсон харилцааг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай (2005), Эрүүл мэндийн тухай (1998), Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль (2002) болон Эрүүл Мэндийн сайдын тушаалаар батлагдсан журмуудаар зохицуулж байна. Эрүүл мэндээ хамгаалуулах эрх хуулийн хүрээнд баталгаажсан хэдий ч зарим нэг дүрэм журмыг өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна. Тухайлбал, Эрүүл Мэнд, Санхүү, Эдийн Засгийн сайдын хамтарсан 2003 оны 21/30 дугаар тушаалаар “Амбулатори, поликлиникээр үнэ төлбөргүй эмчлэх өвчин, түүнд хэрэглэх эмийн жагсаалт”-ыг баталжээ. Энэ нь хэдийгээр иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор төрөөс авч хэрэгжүүлж буй чухал арга хэмжээ боловч, үнэ төлбөргүй авч болох эмийн жагсаалтад орсон эм бэлдмэлүүдийн нэр төрөл цөөн, зориулалт нь хязгаарлагдмал байгаад холбогдох судалгааны байгууллагууд шүүмжлэлтэй хандаж байна⁶. Тухайлбал, уг жагсаалтад үнэ төлбөргүй авч хэрэглэж болох 54 нэр төрлийн эмийг багтаасан ба эдгээрээс 11 нь зөвхөн сэтгэцийн өвчин, эмгэгийг эмчлэх зориулалттай байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст элбэг тохиолддог тархины саажилт зэрэг хавсарсан өвчнүүдийн эмчилгээнд хэрэглэгддэг эм бэлдмэл тэр бүр багтаагүй байна. Түүнчлэн, Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн 2002 оны 03

⁶ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбоо, “Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал” судалгаа 2006 он, 20-р тал

дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн үнийн дээд хязгаар, үнийн хөнгөлөлтийн хэмжээ, тэдгээр эмийн үйлчлэх журам”-ыг баталжээ. Гэвч, энэ журамд хүүхдийн, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эм хэрэглээний талаар тусгай заалт огт алга байна.

17. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбогдсон харилцааг Хөдөлмөрийн тухай (1999), Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай (2005), Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай (2001) зэрэг хууль тогтоомжоор зохицуулсан байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1-д “50, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил албан тушаалынхаа гурав, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна”, 111.2-т “аж ахуйн нэгж байгууллага энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө” гэж заасан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн чухал хөшүүрэг боловч хуулийн заалт хэт ерөнхий, улс орны нөхцөл байдалд төдийлөн нийцэж чадаагүй байна. Тухайлбал, цэрэг, цагдаа, гамшгаас хамгаалах зэрэг байгууллагууд хуулийн дээрх заалтыг манайд хамаарахгүй гэж үзэж буйг анхаарах асуудал мөн. Нөгөө талаас, хөдөө, орон нутгийн хувьд 50, түүнээс дээш ажиллагсадтай аж ахуйн нэгж, байгууллагуудын тоонд ихэвчлэн төсвийн эмнэлэг, сургууль, төрийн захиргааны байгууллагууд тоологдож, компани, ажахуйн нэгжүүд тус хуулийн үйлчлэлийн гадуур үлдэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу богиносгож болно гэж заасан боловч хэрхэн яаж богиносгохыг зохицуулсан эрх зүйн акт байхгүй байгааг Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам анхааралдаа авах шаардлагатай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой хууль тогтоомж, төрийн бодлого хангалттай байгаа хэдий ч

тэдгээр иргэдийн хувьд ажил хөдөлмөр эрхлэх орчин бүрдээгүй, ажлын байрны стандарт өнөөг хүртэл боловсруулагдаагүй, ажил, амралт, цалин хөлсний зохицуулалт бүрхэг байгаа нь энэ чиглэлд дорвитой өөрчлөлт гарч чадахгүй байх шалтгаан гэж үзэж байна.

18. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай (2005), Барилгын тухай (1998), Боловсролын тухай (2002) зэрэг хуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн дэд бүтцийг бий болгох тухай заасан байна. Түүнчлэн, энэ талаар Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр (2003), Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2006), Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2004)-т тус тус тусгагдсан. Гэвч хууль тогтоомж, бодлого хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа холбоо дутмаг, бүх төрөл хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай хэрэгцээнд нийцсэн дэд бүтцийг бий болгох, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хүнийхээ хэрэгцээнд нийцүүлэх, салбарын хууль тогтоомжид суулгах ажил туйлын хангалтгүй хийгдэж байна. Тухайлбал, Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т “нийтийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийн зураг төсөл нь барилгын норм, дүрэмд заасны дагуу тулгуур эрхтний согогтой тахир дутуу хүний хэрэгцээг харгалзан боловсруулагдсан байна” гэжээ. Хуулийн энэ заалтад зөвхөн тулгуур эрхтний согогтой хүний асуудлыг авч үзсэн байгаа бөгөөд харааны, сонсголын, сэтгэцийн гэх мэт бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг орхигдуулсан байна. Барилгын тухай хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх үүднээс Барилга, Хот Байгуулалт, Нийтийн Аж Ахуйн Газрын даргын 2004 оны 17 дугаар тушаалаар “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” /БД 31-101-04/-ийг баталжээ. Энэхүү журам нь барилгыг шинээр барих, хэсэгчлэн өргөтгөл хийх, байгуулалтуудыг өөрчлөн шинэчлэх, хотын орон зайг шинэчлэх, өөрчлөх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулж өрөө тасалгааны зориулалтыг зөв тогтоох, тавилга, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжүүдийг оновчтой байрлуулах удирдамж бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй

иргэдийн орчны хязгаарлалтын асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой баримт бичиг болсон байна. Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нийцсэн дэд бүтцийг бий болгох тухай заалтууд Барилга, Нийтийн Аж Ахуйн Газраас баталсан “Олон нийтийн барилга, төлөвлөлтийн нормаль” /БД 31-03-03/, “Захиргаа ба аж ахуйн барилгын нормаль” /БД 31-04-03/, “Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм” /БД 31-03-01/, “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” /БД 30-01-03/ зэрэг актуудад тусгагджээ. Гэвч эдгээр нормаль, баримт бичгүүд нь улсын стандарт биш учраас барилгын төлөвлөлтөд бүрэн хэмжээгээр тусч чадахгүй байна. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилга, байгууламж, дэд бүтцэд тавигдах норм, шаардлагуудыг улсын стандарт болгон хот төлөвлөлтийн бодлогод мөрдүүлэх шаардлагатай байна.

19. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.2-т “телевизийн мэдээллийн нэвтрүүлгийг дохионы хэлний орчуулагчтай гаргах”, 9.3.3-т “нийтийн тээврийн хэрэгсэл, төмөр зам, орон сууц, албан байгууллага, нийтийн үйлчилгээний газрын орц, гарц, гэрэлтүүлэг, бие засах газрын зорчих хэсгийг эдгээр иргэдийн хязгаарлагдмал боломжид тохируулан хийх”, 9.3.4-т “гэрлэн дохио, нийтийн үзвэр, үйлчилгээний газрын талбай, зам, харилцаа холбооны хэрэгсэл эдгээр иргэдийн хэрэгцээ, шаардлагад зохицсон байх” тухай заасан байдаг. Харин Харилцаа, холбооны тухай (2001), Авто замын тухай (1998), Авто тээврийн тухай хууль (1999)-д энэ талаар тусгайлсан заалт байхгүй байна. Ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хүртээмжтэй болгох талаар эрх зүйн орчинг боловсронгуй болгох, энэ талаар төрийн бодлого бий болгох шаардлагатай байна. 2006 оноос эхлэн Зам Тээвэр, Аялал Жуулчлалын Яамнаас “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон дугуйтай хүн, явган зорчигчдын зориулалтын зам”-ын үндэсний стандартыг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих зориулалтын тоноглол бүхий тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор

судалгааны ажлыг эхлүүлсэн нь ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ мөн.

20. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, орчны саадыг арилгах, тэдгээр хүмүүсийн тусгай хэрэгцээнд нийцсэн дэд бүтцийг бий болгоход татварын орчны хөнгөлөлт, урамшууллын бодлого чухал ач холбогдолтой юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхүүднээс хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлөх, ийм иргэн ажилладаг аж ахуйн нэгжид нийт ажилтнуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эзэлж байгаа хувь хэмжээгээр тооцон албан татварын хөнгөлөлт үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай зориулалтын хэрэгслийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай заалтууд татварын хууль тогтоомжид тусгагджээ. Гэхдээ татварын багц хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай хэрэгцээнд нийцсэн автомашин, автобус зэрэг тээврийн хэрэгслийг гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвараас чөлөөлөх тухай тодорхой заалт үгүйлэгдэж байна. Тусгай зориулалтын тээврийн хэрэгслийг татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай эрх зүйн зохицуулалт бий болгох нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд чухал хувь нэмэр болно гэж үзэж байна.

21. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг биеийн тамир, спортод оролцуулах талаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна. Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг орхигдуулсан, энэ салбарын хууль тогтоомжид тэдгээр иргэдийн эрхийг зөрчсөн зүйл, заалт цөөнгүй байна. Тухайлбал, Биеийн тамир, спортын тухай хууль (2003)-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т “Үндэсний шигшээ багийн тогтолцоо нь насанд хүрэгчдийн үндэсний шигшээ, залуучуудын, оюутны, өсвөр үеийн шигшээ багаас бүрдэнэ” гэж заажээ. Дэлхий нийтийн практикт 20 гаруй жилийн өмнөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн параолимп, дэлхийн аваргын тэмцээн зохион байгуулагдаж, улс орнууд хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн шигшээ багийг бүрдүүлэн дасгалжуулж, улсаас дэмжлэг туслалцаа үзүүлсээр ирсэн байна. Биеийн тамир, спортын тухай хуулиар тодорхойлсон үндэсний шигшээ багийн тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шигшээ багийг орхигдуулсан нь тэгш эрхийн зарчимд нийцэхгүй байна. Түүнээс гадна, Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолоор олимпын наадмын тоглолтод багтдаг спортын төрлөөр олимп, тивийн наадам, дэлхий, тивийн аварга, дэлхийн цомын аварга, оюутны универсиад, оюутны дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болон параолимпын наадамд медальт байранд шалгарсан тамирчдыг урамшуулах журам, хэмжээг тогтоожээ. Гэтэл тус тогтоолд хамаарах спортын уралдаан, тэмцээний төрөлд тивийн наадмыг оруулсан атлаа тивийн пара тоглолтыг орхигдуулжээ. Адил түвшний спортын наадамд шалгарсан тамирчдыг шагнаж урамшуулахдаа ялгавартай хандаж байгаа нь хүний эрхийн зарчимд нийцэхгүй байна. Түүнчлэн, адил түвшний спортын тэмцээнд ижил амжилт үзүүлсэн эрүүл болон хөгжлийн бэрхшээлтэй тамирчдад олгох мөнгөн шагналын хэмжээ 10 дахин ялгаатай байгааг анхаарах шаардлагатай юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх статистик

22. Аливаа улс орон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ талаар үнэн бодитой статистик, тоо баримтыг гаргаж, үүндээ тулгуурлан тэдгээр иргэдэд чиглэсэн хууль тогтоомж, бодлогоо тодорхойлох нь төрийн бодлого, үйлчилгээ зохистой, үр дүнтэй байхад ач холбогдолтой билээ. Гэтэл манай улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх статистик, тоо баримт тодорхой бус, эх сурвалжуудын мэдээ маш зөрүүтэй байна.

23. 2004 онд Үндэсний Статистикийн Газраас явуулсан “Тахир дутуу иргэдийн нэг удаагийн бүртгэл” түүвэр судалгаагаар манай улсад нийт 69253 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгдсэн байдаг⁷. Нийт хүн амын 2.8 хувийг эзэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 38.2 мянга буюу 55.2

⁷ 2004 оны 5 дугаар сарын 24-ний байдлаар

хувь нь эрэгтэйчүүд, 31.0 мянга буюу 44.8 хувь нь эмэгтэйчүүд байна. Түүнчлэн, 15 хүртэлх насны хүн амын 0.6 хувь, 15-59 насны хүн амын 3.9 хувь, 60 ба түүнээс дээш насны хүн амын 2.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байгаа бөгөөд нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 9.9 хувь нь 10-19 насныхан, 18.7 хувь нь 20-29 насныхан, 21.9 хувь нь 30-39 насныхан, 27.1 хувь нь 40-49 насныхан байна гэж энэ судалгааны дүнд мэдээлжээ. Харин 1998 онд Эрүүл Мэнд, Нийгмийн Хамгааллын Яамнаас явуулсан түүвэр судалгаагаар манай улсын хүн амын 4.8 хувь нь буюу 115000 орчим хүн хөгжлийн бэрхшээлтэй, тэдгээрийн 18.1 хувь нь оюун ухааны хомсдолтой, 5.6 хувь нь хэл ярианы болон сонсох эрхтний согогтой, 36.5 хувь нь бусад шалтгааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон гэсэн тоон мэдээ гаргаж байжээ. Үндэсний Статистикийн Газраас хийсэн судалгаагаар нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 9.9 хувийг буюу 6900 орчмыг 0-19 насныхан эзэлж байна гэж дүгнэсэн байхад, 2003 онд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамны гаргасан статистик мэдээлэлд 37000 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна гэжээ. Мөн онд Улсын Халамжийн Газраас 34000 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна гэсэн бүртгэл судалгаа гаргасан байна.

24. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх статистик мэдээлэл ийнхүү хэт зөрүүтэй байгаа нь судалгаануудын аргачлал өөр, мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу байгаа төдийгүй холбогдох хууль тогтоомжийн “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэсэн тодорхойлолт бүрхэг байгаатай холбоотой гэж үзэх үндэслэлтэй байна. Иймд иргэд хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа шалтгаан нөхцлийг судалж, түүнээс урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх үндэсний хэмжээний статистик судалгаа хийж, үнэн бодитой тоо баримт гаргаж бодлого, чиглэлээ зөв тодорхойлоход анхаарах цаг нэгэнт болсон байна.

Алагчлалаас ангид байх эрхийн хэрэгжилт

25. Сүүлийн хоёр жилд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай хэрэгцээнд нийцсэн орчин бүрдүүлэх, дэд бүтэц бий болгох талаар арга хэмжээ авч эхэлж байгаа ч дорвитой өөрчлөлт гараагүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орчны саад тотгор нь эцсийн дүндээ тэдгээр иргэд нийгмээс тусгаарлагдан алагчлагдаж, эрх, эрх чөлөө нь зөрчигдөхөд хүргэж байна. Жишээлбэл, төрийн ордноос эхлээд төр засгийн ямар ч барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцээгүй, тэдгээр иргэд орох, гарах боломж, нөхцөл хязгаарлагдмал байна. Түүнчлэн, эдгээр байгууллагуудын гаднах зам, талбайг гялгар хавтангаар өнгөлсөн, энэ нь өвлийн улиралд цас мөсөөр хучигдсан байдгаас хараагүй, тэргэнцэртэй, таягтай хөгжлийн бэрхшээлтэй хүн битгий хэл эрүүл хүн хүртэл хальтирч унах, бэртэж гэмтэх, улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүний тоог нэмэгдүүлэх эрсдэлтэй нөхцлийг бүрдүүлж байна. Төрийн захиргааны төв байгууллагуудын шийдвэр гаргах эрх мэдэл бүхий албан тушаалтнуудын ажлын өрөөнүүд ихэвчлэн хоёроос дээш давхарт байрладаг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зөөвөрлөх шат, лифт байхгүй байгаа өнөөгийн нөхцөлд тэдгээр иргэдийн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхээс эхлээд бусад эрх хангагдахгүйд хүргэж байна. Мөн ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллежууд, урлаг соёлын байгууллагууд, түүгээр ч зогсохгүй клиникийн нэгдсэн болон дүүргийн эмнэлгүүдийн аль нь ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст саадгүй орчинг бүрэн хэмжээгээр бүрдүүлж чадаагүй байна. Харин Монголын Хүүхдийн Ордон, Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн гадна талд тэргэнцэртэй хүн орох, гарахад зориулсан байгууламжийг бий болгох эхлэлийг тавьж чадсан байна. 2006 онд хийсэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал” судалгаанд оролцсон нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 60 хувь нь үзвэр үйлчилгээнд огт хамрагдагүй гээд шалтгааныг нь үзвэр, үйлчилгээний газарт орж гарахад хүндрэлтэй байдаг

гэж 39 хувь, өөрийн хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан үзвэр үзэж чаддаггүй гэж 26 хувь, үзвэр, үйлчилгээний газар гэрээс нь хол байдаг гэж 15 хувь нь хариулсан байгаа нь дэд бүтцийн талаарх шийдвэрлэгдээгүй асуудал хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмээс тусгаарлахад хүргэж буйг харуулж байна.

26. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замын байгууламж бий болгох ажил хангалтгүй байна. Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол дүүрэг болон Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Төвийн орчимд, Сүхбаатар дүүргийн 100 айлын уулзвар, 29 дүгээр тусгай дунд сургуулийн зарим хэсэгт хараагүй, тэргэнцэртэй хүмүүст зориулсан зам, хашлага хийснээс өөр замын байгууламж байхгүй байна. Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай хэрэгцээнд нийцсэн нийтийн тээврийн үйлчилгээний хэрэгсэл огт байхгүй байна.

27. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.2-т “телевизийн мэдээллийн нэвтрүүлгийг дохионы хэлний орчуулагчтай гаргах”, Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.7-д “үндэстний цөөнх, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлэг, давхаргын болон олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангахыг эрмэлзэх” тухай тус тус заасан боловч эдгээр заалтууд хэрэгжихгүй байна. Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз болон Улаанбаатар Бродкастинг Системсийн зарим мэдээллийн нэвтрүүлгүүд алдаг оног дохионы орчуулагчтай гарч байгааг эс тооцвол одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа 16 телевизийн мэдээллийн хөтөлбөрүүд дохионы хэлний орчуулагчтай явагдаж чадахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хангалттай мэдээлэл хүлээн авч чадахгүй байгаа нь дээрх нөхцөл байдалтай шууд холбоотой гэж үзэж байна. 2005 онд хийгдсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 55 хувь нь хууль зүйн мэдлэг байхгүй

гэж хариулсан байгаа нь тэдгээр иргэдийн мэдээлэл хүлээн авах эрх хангагдаж чадахгүй байгааг харуулж байна.

28. Сүүлийн жилүүдэд мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбар хурдацтай хөгжиж байгаа боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байж чадахгүй байна. Хараагүй хүнд зориулсан тактилан товчлууур бүхий компьютер, техникийг хэрэглээнд нэвтрүүлэх талаар холбогдох төрийн байгууллагаас өнөөг хүртэл ямар нэг арга хэмжээ аваагүй, энэ талаар тодорхой бодлого үгүйлэгдэж байна.

29. Орчны саад бэрхшээлээс шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгуульд тэр бүр оролцох боломжгүй байна. Брайль үсэг бүхий саналын хуудас байхгүй, сонгуулийн санал авах байранд хараагүй, одой, тэргэнцэртэй иргэдийн хэрэгцээнд нийцсэн тусгай кабингүй болон саналын хайрцгийг ямар хэмжээний өндөрт байрлуулах тухай стандарт байдаггүйгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэгш, чөлөөтэй, шууд сонгуульд оролцох боломж, нөхцөл бүрдээгүй байна⁸.

30. Спортын салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг алагчлах хандлага түгээмэл байна. Хөгжлийн бэрхшээлтэй тамирчид бэлтгэл сургуулилт хийх боломж нөхцөл байдаггүй, энэ талаар төрийн холбогдох байгууллагад үүрэг хүлээлгэсэн эрх зүйн зохицуулалт байхгүй болон тэмцээн уралдаанд амжилт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг шагнаж урамшуулахад ялгавартай бодлого баримталж байгаа нь хүний эрхийг зөрчиж байна. Түүнчлэн, Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолд олимпын наадамд алтан медаль авсан тамирчинд 120 сая, мөнгөн медальд 48 сая, хүрэл медальд 24 сая төгрөг олгохоор заасан атлаа параолимпын наадамд алтан медаль авсан тамирчинд 12 сая, мөнгөн медальд 4.8 сая, хүрэл медальд 2.2 сая төгрөгийн шагнал олгохоор заасан нь хэт зөрүүтэй, алагчилсан шинжтэй байна.

⁸ Хүний Эрхийн Үндэсний Комисс “Сонгуулийн хууль тогтоомжид сонгох, сонгогдох эрхийн үүднээс хийсэн дүн шинжилгээ”, 2005 он, 8-р тал

...Катар Улсын Доха хотод зохион байгуулагдсан Азийн 15 дугаар наадамтай зэрэгцэн зохион байгуулагдсан Ази тивийн 9 дэх удаагийн пара тоглолтод Монгол Улсаас жудо бөх, марафон гүйлт, байт харваа, буудлагын спортын төрлүүдээр 7 тамирчин оролцож, 1 мөнгө, 3 хүрэл медалийн амжилт үзүүлжээ.

Азийн пара тоглолтод амжилттай оролцож, медальт байранд шалгарсан тамирчид 2006 оны 12 дугаар сард Засгийн газрын 208 дугаар тогтоолын дагуу холбогдох материалыг бүрдүүлэн Эрүүл Мэндийн дэд сайдын нэр дээр хүргүүлсэн байна.

Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий Сайдад өргөдөл гаргаж байжээ. Харамсалтай нь, тэд өнөөг хүртэл тавьсан өргөдөл, хүсэлтийнхээ талаар ямар нэг хариу хүлээж аваагүй байна...

*ХЭҮК-т иргэдээс ирүүлсэн гомдол,
Картын дугаар 2007/14*

31. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн тусламж, дэмжлэгийн объект биш, эрх эдэлж үүрэг хүлээх нийгмийн тэгш эрхэт гишүүн болох талаас нь хүлээж авах олон нийтийн ойлголт, хандлага төлөвшөөгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 2 дугаар бүлгийн 2.4.6, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөрийн 5.8-д хөгжлийн бэрхшээлтэй хүний талаархи нийгэм, сэтгэл зүйн таатай орчинг бүрдүүлэх талаар тусгасан боловч хөгжлийн бэрхшээлийн асуудалд хүний эрхийн үүднээс хандах олон нийтийн хандлагыг бий болгоход чиглэгдсэн үнэн бодитой мэдээлэл нийгэмд тэр бүр хүрч чадахгүй байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлийн талаарх сэтгүүлч мэргэжилтнүүдийн мэдлэг, ойлголт муу, энэ асуудалд хүний эрхийн үүднээс хандаж чадахгүй байгаатай холбоотой юм.

32. Өдөр тутмын сонинд хэвлэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой мэдээллийг агуулгаар нь авч үзэхэд, мэдээллийн 25 гаруй хувь нь төр болон олон улсын байгууллага, олоннийтийн хөдөлгөөнөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан хийж бүтээж буй ажил, үйлчилгээний талаар дурдсан, 20 гаруй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажил, амьдралын тухай хөрөг нийтлэл, 15 орчим хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллагын мэдээлэл, мөн 15 орчим хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой асуудал дэвшүүлсэн хийгээд шүүмжилсэн нийтлэл, үлдсэн хувь нь сурталчилгааны болон хандив, тусламж хүссэн мэдээллүүд байна⁹.

33. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр тодорхой хэмжээнд цацагдаж байгаа боловч мэдээллийн агуулгад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэр хүнд хийгээд эрхэд шууд болон шууд бусаар халдсан, үл хүндэтгэсэн, бүдүүлэг үг хэллэг ашигласан зэрэг байдлууд ч мөн цөөнгүй байгаа нь нийгмийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж байгаа юм. Тухайлбал, 1999 онд Эрүүл Мэнд, Нийгмийн Хамгааллын Яамны захиалгаар Монгол Улсын Их Сургуулийн социологийн тэнхимээс хийсэн “Тахир дутуу иргэдийн нийгмийн хэрэгцээ” судалгаанд оролцогчдын 71,4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусад хүмүүсээс ялгаатай “өөр хүмүүс” гэж үзэж байжээ. Судалгаанд оролцогчдоос хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг “нийгмийн эмзэг” бүлгийн, өвчин, эмгэгтэй хүмүүс гэж 23,8 хувь, нийгмийн зүгээс анхаарал, халамж байнга шаарддаг хүмүүс гэж 45,5 хувь нь үздэг талаар тэмдэглэжээ. Мөн судалгаанд оролцогчдын 52,8 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээс авдаг, 14,7 хувь нь тэдний

⁹ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрмийн хэрэгжилтийн байдал” судалгааны төслийн хүрээнд хийгдсэн хэвлэлийн контент анализын дүнгээс

талаарх мэдээлэл авч чаддаггүй, харин 3.1 хувь нь мэдээлэл авахыг ч хүсдэггүй гэсэн байна.

Нийгмийн халамж, хамгаалал хүртэх эрхийн хэрэгжилт

34. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэгдсэн нийгмийн хамгааллын үйлчилгээ хүрэх ёстой хүмүүстээ бүрэн гүйцэд хүрч чадахгүй байна. Үндэсний Статистикийн Газрын нэг удаагийн бүртгэл, түүвэр судалгаагаар нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 11.6 хувь буюу 8000 гаруй иргэн Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлээ тогтоолгоогүй байсан тухай тоон мэдээ гарчээ. Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлээ тогтоолгоогүй байдлыг шалтгаанаар нь авч үзвэл хаана хандахаа мэдэхгүй, бичиг баримт бүрдэлгүй, өөрөө хүсдэггүй зэрэг шалтгаан тус бүр 10 гаруй хувийг, мөн унааны зардал хүрэлцдэггүй гэх шалтгаан 6 хувийг эзэлж байна. Түүнчлэн, 2006 онд Филантропи хөгжлийн төлөө төвийн хийсэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрмийн хэрэгжилт” судалгаанд хамрагдсан нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 22.6 хувь нь нийгмийн халамжийн байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлдэг хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагддаг гэсэн бөгөөд үлдсэн 77.4 хувь нь буюу 2057 иргэн үүнд хамрагдаж чаддаггүй гэжээ. 2005 онд Италийн Засгийн газрын бус Раул Фалерогийн Анд Нөхдийн Холбоо (АЙФО) байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд хийгдсэн судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцсон таван хүн тутмын хоёр нь нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй гэсэн байна.

35. 2005 онд батлагдсан Нийгмийн халамжийн тухай хуульд зааснаар нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй бүрэн хараагүй, хэлгүй, дүлий болон одой хүн, хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан хөгжлийн

бэрхшээлтэй хүн нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрхтэй болсон нь өмнөх хуулиар 70-аас доош хувийн хөдөлмөрийн чадвар алдалттай нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдаж байсан бүх хүмүүсийн эрх зүйн байдлыг дордуулж, тэтгэврийг зогсооход хүргэсэн байна. Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Газраас авсан албан ёсны эх сурвалжийн мэдээгээр 2007 онд багтаж 20000 хүний нийгмийн халамжийн тэтгэвэр зогсоогдох төлөвтэй байна¹⁰.

36. Эрүүл Мэнд, Нийгмийн Хамгааллын сайдын хамтарсан 1997 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан “Ердийн болон Мэргэжлээс шалтгаалах өвчний жагсаалт”-д зааснаар хөдөлмөрийн чадвараа 70-аас доош хувиар алдсанд тооцогдож, нийгмийн халамжийн тэтгэвэр нь зогсоогдсон хүмүүст хөнгөн хэлбэрийн оюуны хомсдолтой, шилбэ, шууны тайралттай, түнхний мултралттай, өрөөсөн нүүдгүй, сулхараатай, сул сонсголтой, ортопед гутал хэрэглэдэг хүмүүс хамрагдаж байна¹¹. Хөгжлийн бэрхшээлтэй олон мянган иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг хорогдуулж, ангилал өөрчлөгдөхөд хүргэж буй дээрх шийдвэрт энэ чиглэлээр ажилладаг байгууллагууд шүүмжлэлтэй хандаж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөр эрхлэх таатай орчин бүрдэж чадаагүй байгаа өнөөгийн нөхцөлд холбогдох эрх бүхий байгууллагын зүгээс асуудлыг дахин судлан үзэх шаардлагатай байна.

37. Түүнчлэн, дээр дурдсан Эрүүл Мэнд, Нийгмийн Хамгааллын сайдын хамтарсан 1997 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан “Ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний жагсаалт”-д мэргэжлээс шалтгаалан тусч болох зарим өвчнийг ердийн өвчинд тооцохоор заасан, нөхөн сэргээгдэх бололцоогүй зарим өвчин, гэмтлийн хувь хэмжээг багасган тогтоосноос хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зөрчигдөхөд хүрч байна.

¹⁰ Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Газрын мэдээ, 2007.03.01

¹¹ Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбоо

...“МахИмпекс” компанидажиллажбайсанхэсэгиргэдээс Хүний Эрхийн Үндэсний Комисст хандан малын халдварт бруцеллээс өвчнийг “Мэргэжлээс шалгаалах өвчний жагсаалт”-аас хассан нь Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасан эрхийг нь зөрчиж байгаа тухай гомдол ирүүлсэн юм. Гомдолд дурдагдсанаар Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн бруцеллээсын тасгийн диспансерын хяналтанд байх 156 өвчтөний 96 нь “Мах Импекс” компанид ажиллаж байсан хүмүүс, 37 нь малын эмч, 9 нь зоотехникч, бусад нь “Мон ноос” ХХК, “Говь” ХХК, Арьс ширний үйлдвэр, Сүүний үйлдвэр, Био үйлдвэр, Гахайн ферм зэрэг газруудад ажиллаж байжээ. Бруцеллээс өвчнийг мэргэжлээс шалтгаалах өвчний жагсаалтаас хассанаас эдгээр хүмүүсийн эрх ашиг хөндөгдөж, зарим талаар хохироход хүрсэн байна.

Эдгээр өвчтөнүүд бүгд эрхэлж байсан ажил мэргэжлээсээ шалтгаалан уг өвчин туссан нь тогтоогдож, эрх бүхий мэргэжлийн байгууллагын акт үйлдэгдсэн байна. Энэ талаар Хүний Эрхийн Үндэсний Комиссоос Эрүүл мэндийн Яам, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яаманд хандсан боловч өнөөг хүртэл асуудлыг бодитойгоор шийдвэрлээгүй байна...

*ХЭҮК-т иргэдээс ирүүлсэн гомдол,
Картын дугаар 2006/147*

38. Өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамжийн тэтгэвэр 26500 төгрөг байгаа нь тэдгээр иргэдийн амьжиргааны наад захын хэрэгцээг хангаж чадахгүй байна.

39. Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд холбогдох төрийн байгууллагууд онцгойлон анхаарал хандуулж, сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна. 2005 онд батлагдсан Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу 70 ба түүнээс дээш хувиар хөдөлмөрийн чадвар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр авах болсонтой холбоотой эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс иргэдийн хөдөлмөрийн

чадвар алдалтын хувийг магадлан тогтоохдоо мэргэжлийн үүднээс нарийн, тодорхой нягтлалгүйгээр хавтгайруулан 70 хувиас доош тогтоосон тухай гомдол Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоонд олноор ирэх болсон тухай мэдээлэл байна. Өнгөрсөн онд зөвхөн Дорнод аймгаас гэхэд ийм төрлийн 4 гомдол иржээ. Түүнчлэн, эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангахад чиглэгдсэн тусгай зохицуулалт үгүйлэгдэж байгааг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд шүүмжилж байна.

40. Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 10 гаруй төрлийн хөнгөлөлт үзүүлдэг бөгөөд эдгээр нь тэдний амьдрал ахуйд тодорхой дэмжлэг, туслалцаа болдог байна. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг тэтгэврийн насанд хүртэл нь олгож, сувилалд хэвтэж эмчлүүлэх тохиолдолд сувиллын зардал, унаа, хиймэл эрхтэн, засал эмчилгээний тодорхой нөхцөлт зардлуудыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлж байна¹². Тухайлбал, сүүлийн 5 жилд 6.0 мянга орчим даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ хийлгэх, рашаан сувилалд эмчлүүлэхэд зориулж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 440.7 сая төгрөг зарцуулсан дүн мэдээ байна¹³. Хэдийгээр төрийн бодлого, үйл ажиллагааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын асуудалд анхааран зохих төсөв хөрөнгө зарцуулсаар байгаа ч нийгмийн хамгааллын үйлчилгээг авбал зохих хүн нэг бүрд нь тэгш, хүртээмжтэй хүргэхэд анхаарах шаардлагатай байна.

¹² Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль 2004 он

¹³ <http://www.ndaatgal.mn>

Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийн хэрэгжилт

41. Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлд сэтгэцийн эмгэгийн эмчилгээ, удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн зардлыг төрөөс хариуцахаар заажээ. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэд зарим эмийн үнийн хөнгөлөлт авах боломжтой байна. Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ хүргэх талаар нэлээдгүй арга хэмжээ авч байгаа бөгөөд ялангуяа, Эрүүл Мэндийн Яамнаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сэргээн засах үйлчилгээг нийгэм хамт олонд түшиглэн явуулах, энэ ажилд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчид, эрүүл мэндийн сайн дурын туслагч, нийгмийн ажилтнуудыг идэвхтэй оролцуулах бодлогыг баримтлан ажиллаж байгаа нь сайшаалтай байна. Гэсэн хэдий боловч, эрүүл мэндийн салбарт хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний нэр төрөл цөөн, цаг үеэс хоцрогдсон, хүн бүрт хүртээмжтэй байж чадахгүй байгаа зэрэг дутагдал байна. 2005 онд хийгдсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” судалгааны санал асуулгад хариулсан байдлаас харахад судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 40 хувь нь, тэдний асран хамгаалагчид, гэр бүлийн гишүүдийн 77.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх хангагдаж чаддаггүй гэж үнэлсэн байна¹⁴.

42. Эрүүл мэндийн салбарт “Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх”, “Хүн амын эрүүл мэндийн боловсрол”, “Иод дутлын эмгэгтэй тэмцэх”, “Осол гэмтлээс сэргийлэх”,

¹⁴ 2005 онд Италийн Засгийн газрын бус АИФО байгууллагын санхүүжилтээр хэрэгжсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд хийгдсэн асуулгын судалгааны үр дүн Улаанбаатар, 2005 он

“Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах”, “Сохролоос урьдчилан сэргийлэх”, “Амны хөндийн эрүүл мэнд”, “Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөр зэрэг олон тооны төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах, иргэдийг хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Гэвч ядуурал, амьжиргааны таагүй орчин, хөдөлмөрийн аюултай нөхцөл, хайхрамж болгоомжгүй байдал, осол гэмтлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх мэдлэг, арга ажиллагаа дутмагаас хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо өсөн нэмэгдэж байгааг анхаарч, хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа холбоо, үр нөлөөг сайжруулж, бодитоор хэрэгжүүлэх, иргэдэд жигд хүртээмжтэй болгох шаардлагатай байна. Үндэсний Статистикийн Газрын судалгаагаар нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 64.5 хувь нь олдмол хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй болсон байгаа бөгөөд тэдгээрийн 62.6 хувь нь ердийн өвчнөөр, 15.8 хувь нь ахуйн ослоор, 8.7 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөр, 2.7 хувь нь үйлдвэрлэлийн ослоор ийм байдалд хүрчээ.

43. Монголчуудын уламжлалт амьдралын хэв маягтай холбоотой морь малаас унаж бэртэх зэргээс хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол хөдөө, орон нутгийн иргэдийн дунд түгээмэл байна. Түүнчлэн, сүүлийн үед өвөл, зуны аль ч улиралд өргөнөөр зохион байгуулагдах болсон хурдан морины уралдааны үеэр хүүхэд бэртэх, улмаар хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол цөөнгүй гарч байна. Тухайлбал, 2006 онд улсын хэмжээнд зохион байгуулагдсан их, бага морины уралдаануудад 10000 орчим хүүхэд морь унасан байгаа бөгөөд тэдгээрийн 500 орчим нь уралдааны явцад бие эрхтэндээ бэртэл, гэмтэл авсан байна. Бэртэл, гэмтлийн зэргийн хувьд авч үзвэл 39.8 хувь нь хөнгөн, 31.0 хувь нь хүндэвтэр, 20.8 хувь нь хүнд гэмтэл авчээ¹⁵.

44. Төрөлт, төрөлтийг удирдах явцын алдаанаас эрүүл тээгдэж байсан хүүхэд тархины саажилттай болж байгаа тохиолдол анхаарал татаж байна. Тухайлбал, Налайх

¹⁵ Хүүхдийн Төлөө Үндэсний Газар

дүүргийн Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Хэлтсийн дэргэд Дэлхийн Зөн байгууллагын санхүүжилтээр ажиллуулж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн яслид 2007 оны 1 дүгээр сарын байдлаар 0-5 насны 15 хүүхэд хамрагдаж байгаагийн 4 нь дээрх шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй болжээ.

45. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд цахилгаан, хөдөлгөөн, рашаан, агаар, нар, усан, шавар эмчилгээ болон иллэг бариа, зүү төөнүүр, бясалгал зэрэг нөхөн сэргээх эмчилгээг хийж байна. Нөхөн сэргээх тусламж үйлчилгээ хөдөө орон нутагт харилцан адилгүй бүтэцтэй, ихэвчлэн уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээтэй хавсруулсан кабинет, тасгийн зохион байгуулалттай, хот суурин газрын томоохон эмнэлгүүдийн хувьд ихэвчлэн амбулаториор тусламж, үйлчилгээ үзүүлдэг байна. Эрүүл мэндийн салбарын нөхөн сэргээх тусламж үйлчилгээ нь бие даасан тодорхой бүтэц байхгүй байгааг анхаарч, нөхөн сэргээх эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг боловсруулах шаардлагатай байна¹⁶.

46. Нөхөн сэргээх үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамралт харьцангуй доогуур байгааг 2004 онд Эрүүл Мэндийн Яамнаас хийсэн “Монголын нөхөн сэргээх тусламжийн өнөөгийн байдал” судалгааны тайланд дурджээ. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 47.1 хувь нь бие эрхтний ажиллагааг нөхөн сэргээх эмчилгээнд, 51.4 хувь нь алдагдсан ажиллагааны хязгаарлалтыг нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдаж байсан бол 33.1 хувь нь эмнэлгийн үйлчилгээ, эмчилгээнд огт хамрагдаж байгаагүй ажээ. 2006 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооноос хийсэн “Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал” судалгаанд хамрагдсан 975 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээс хот суурин газар амьдардаг хүүхдүүдийн 70.5 хувь, хөдөө, орон нутагт амьдардаг хүүхдүүдийн 73.0 хувь нь сэргээн засалтын ямар ч тусламж, үйлчилгээг авч чадаагүй байна. Сэргээн засах үйлчилгээнд хамрагдаагүйн шалтгааныг

¹⁶ Эрүүл Мэндийн Яам, “Монголын нөхөн сэргээх тусламжийн өнөөгийн байдал” судалгааны тайлан, 2004 он, 41-р тал

санхүүгийн боломжгүй, хаана хандахаа мэдэхгүй, нэгэнт хэрэггүй гэж үздэг, нөхөн сэргээх үйлчилгээний талаар мэдэхгүй, орон нутагт тийм үйлчилгээ байхгүй гэж хариулжээ.

47. Эрүүл мэндийн байгууллагуудаас нөхөн сэргээх тусламжийн үйлчилгээ үзүүлэхэд тулгарч буй томоохон бэрхшээл бол уг эмчилгээнд хэрэглэгддэг тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл шаардлага хангахгүй байгаа явдал юм. Тухайлбал, дээр дурдсан Эрүүл Мэндийн Яамны хийсэн судалгаанд хамрагдсан эмч, эмнэлгийн ажилтнуудаас авсан санал асуулгаар эмнэлэг, тасгийнх нь үйл ажиллагаанд байгаа дутагдлыг тоног төхөөрөмж хуучирсан гэж 70 хувь, өргөжүүлэх шаардлагатай гэж 22 хувь, ачаалал ихтэйгээс эмчилгээний чанарт нөлөөлдөг гэж 8 хувь нь үзсэн байна¹⁷.

48. Хүний Эрхийн Үндэсний Комиссын зөвлөмжийн дагуу Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Хүүхдийг Ивээх Сан (Их Британи) хамтран Улаанбаатар хотноо хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх төв байгуулах асуудлыг холбогдох төрийн байгууллагуудад тавьж шийдвэрлүүлсэн нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн өмнө тулгарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх нааштай эхлэл боллоо.

49. Хууль тогтоомжид заасны дагуу нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлж буй хөнгөлөлтийн нэлээд хэсэг нь туслах хэрэгслийн хангалттай холбоотой байдаг. Тухайлбал, 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийг хоёр удаа 100 хувь нөхөн олгох, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг эхний удаа 100 хувь, хоёр дахь удаа 50 хувь нөхөн олгох, ядуу амьдралтай өрхийн 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй, ядуу амьдралтай өрхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг нэг удаа нөхөн олгох зэрэг хөнгөлөлтүүд

¹⁷ Мөн судалгааны тайлан, 43-р тал

байдаг байна. Сэргээн Засалтын Үндэсний Төв нь 2006 оны эхний хагаст 1561 хүнд үйлчилж 70773.3 сая төгрөгийн протез, ортопедийн хэрэгсэл үйлдвэрлэсний 16223.1 сая төгрөгийг буюу 22.9 хувийг нийгмийн халамжийн сангаас нөхөн төлжээ¹⁸. Гэвч туслах хэрэгслийн хөнгөлөлтөд хамрагдахад хуулийн өндөр шалгуур тавигддаг, хүртээмж муу, нийгмийн халамжийн байгууллагуудаас нийлүүлж буй туслах хэрэгслийн чанар хэрэглэх хүнийхээ шаардлагад нийцэхгүй зэрэг дутагдал байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг туслах хэрэгслээр хангах, тэдэнд хөнгөлөлт үзүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ тэдгээр иргэдийн өөрсдийн үүсгэл санаачлагын байгууллагаар дамжуулан хүргэдэг тогтолцоог бий болгох тухай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудаас гарч буй санал нь төрийн халамж, үйлчилгээг жинхэнэ хүртэх ёстой эздэд нь хүргэх, асуудалд шударга хандахад тус дөхөм үзүүлэх зөв зүйтэй санал гэж Хүний Эрхийн Үндэсний Комисс үзэж байна.

50. “Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал” судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн дөнгөж 20.0 хувь нь протез, ортопедын хэрэгсэлтэй байжээ¹⁹. Туслах хэрэгслийн үнэ нь төрөл, хэмжээ, загвар, материалаас шалтгаалан 10000-250000 орчим төгрөг байгаа бөгөөд энэ нь орлого багатай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд боломжийн хямд үнэ байж чадахгүй байна.

51. Нийгмийн халамжийн байгууллагаас нийлүүлж буй тэргэнцэр, сонсголын аппарат зэрэг хэрэгслийн чанар шаардлага хангахгүй байгаа талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зүгээс төрийн холбогдох байгууллагад гомдол, санал байнга тавьж байгаа боловч асуудал дорвитой шийдвэрлэгдэхгүй хэвээр байна. Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах хэрэгслийг төрийн албан хаагчийн нэрийн дор шоу, сурталчилгаа хэлбэрээр олгож байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хэт доогуур үзсэн, нэр хүндэд

¹⁸ Филантропи төв, “Хөгжлийн Бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрмийн хэрэгжилт”, 2006 он, 26-р тал

¹⁹ ХБХЭЭХ, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал” судалгаа, 2006 он, 48-р тал

нь таатай бус байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан туслах хэрэгслийн хүртээмж, чанарыг сайжруулж, үнэ өртгийг хямдруулах талаар бодитой, тодорхой ажил зохион байгуулах шаардлагатай байна.

... Сонсголын аппарат, тэргэнцэр, таяг олдоц муутай, нэг удаа хийгдсэн протезууд шаардлага хангахгүй болсноос дахин хийлгэж чаддаггүй байна. Зарим сонсголын аппарат нь шуугиад чанарын шаардлага хангахгүй байгаа талаар хэд хэдэн сумдаас гомдол тавьж байна.

... Дүлий хүмүүст олгож байгаа Хятад улсад үйлдвэрлэсэн сонсголын аппарат нь хүний биед муугаар нөлөөлж сонсголыг нь улам муутгаж байна.

ХЭҮК-оос 2003 онд хийсэн “Тахир дутуу иргэдийн эрхийн төлөв байдал” судалгааны материалаас...

... Тулгуур эрхтний согогтой хүмүүст тусгай таяг өгөх ёстой. Гэтэл настай хүнд зориулсан таяг олгогддог.

Экспертын ярилцлагын тэмдэглэлээс ...

Сурч боловсрох эрхийн хэрэгжилт

52. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд заасны дагуу сүрьеэ зэрэг архаг халдварт өвчний халдвартай үед байгаагаас бусад тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл иргэдтэй сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй гэжээ. Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна”, 43 дугаар зүйлийн 43.2.7-д “хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг сурах нөхцөл бололцоогоор төрөөс хангах” гэж тус тус заасан байна.

53. Гэвч орчны саад бэрхшээл, нийгмийн сөрөг хандлага, сургалтын хөтөлбөр, үнэлгээний нийцгүй байдал, багшлах боловсон хүчин болон сургалтын хэрэглэгдэхүүний дутмаг байдлаас шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрх зөрчигдсөөр байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулан сургах, интеграцчилсан сургалтын арга барилыг нэвтрүүлэх бодлогыг төрөөс баримталж, энэ талаар Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамнаас хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаа боловч уг хөтөлбөрийг бодитоор хэрэгжүүлэх үндэс суурь бүрдэж бий болоогүй байна. Тухайлбал, Улаанбаатар хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн өмчийн 200 орчим ерөнхий боловсролын хоёр²⁰ сургуульд л хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцахад тохиромжтой дэд бүтцийг бий болгосон байна. Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах согог зүйч зэрэг тусгай мэргэжилтэн, багш наржирийн сургуулиудад бүү хэл тусгай хэрэгцээт боловсролын байгууллагуудад ч дутагдалтай байна.

54. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролд тэгш хамрагдахад бэрхшээл учруулж буй өөр нэг хүчин зүйл нь сэтгэл зүйн орчин бүрдэж чадаагүй байдал юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ихэнх нь бага насаа хязгаарлагдмал, гэр бүлийн орчинд өнгөрүүлж байгаа учраас бусадтай харьцахад хүндрэл учрах, ичих, эмээх бэрхшээл байдаг байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, үе тэнгийнхэн болон сургуулийн удирдлага, багш нарын зүгээс тэдний эрхэм зэргийг нь хүндэтгэн харьцах хандлага төлөвшөөгүй байна. “Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал” судалгаанд хамрагдсан сургуульд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 46.6 хувь нь бусад хүүхдүүд шоолж дээрэлхдэгээс суралцахад нь хүндрэл, бэрхшээл тулгардаг гэж тодорхойлжээ²¹.

²⁰ Ерөнхий боловсролын 15, 80 дугаар сургууль

²¹ Мөн судалгааны тайлан, 37-р тал

...Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг цэцэрлэгт хүмүүжээд гарсан ч сургуульд авахад таагүй ханддаг. Жишээ нь, Улиастай сумын 10 жилийн 3 дугаар сургуулийн 1 дүгээр ангид хэлгүй, дүлий 2 хүүхдийг өгөх гэтэл татгалзаж байв. Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар зөвлөлд сард ирдэг өргөдөл, хүсэлтийн 80-90 хувийг хэлгүй, дүлий хүүхдийг сургуульд суралцуулж өгөөч гэсэн хүсэлт байдаг.

ХЭҮК-оос 2003 онд хийсэн “Тахир дутуу иргэдийн эрхийн төлөв байдал” судалгааны материалаас, Завхан аймаг

55. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг жирийн сургуульд хамруулан сургахад ашиглагдах сургалтын модуль байхгүй, гарын авлага, хэрэглэгдэхүүн нэн хомсдолтой байна. Түүнчлэн, тэдгээр хүүхдүүдэд тохирсон үнэлгээний аргачлалыг бий болгох шаардлагатай байна. Эрүүл хүүхдийн сургалтын үнэлгээний аргаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийнхийг үнэлдэг нь ерөнхий боловсролын сургуулиудад сурлагын хоцрогдол гарах нөхцлийг бий болгодог бөгөөд энэ нь нөгөө талаас сургуулийн удирдлагууд сургалтын үзүүлэлтийг доош нь татна гэдэг шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээн авахаас цааргалдаг байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн орчинд боловсрол эзэмших нийгмийн сэтгэлзүйг бий болгох, нийт сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах, багш, согог зүйч мэргэжилтэн, орчин нөхцлөөр хангах, аль болох тусгай хэрэгцээт сургуулиас татгалзах бодлого, чиглэлийг баримтлан ажиллах шаардлагатай байна.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

...Өнөөдөр тэгш хамруулах боловсролын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг жирийн ангид сургахад анги дүүргэлт их учраас маш хүндрэлтэй. Иймээс анги дүүргэлтийн тоог цөөрүүлэх хэрэгтэй.

Тэгш хамруулан сургах үзэл баримтлал нь одоогоор тунхагийн шинжтэй л байна. Бүх хүмүүс хүүхэд бүхэн тэгш сурч боловсрох эрхтэй гэж үздэг ч цагаа тулахаар энэ асуудалд анхаардаггүй. Багш нар эдгээр хүүхэдтэй ажиллая гэхээр бэрхшээлд нь тохирсон гарын авлага, яаж ажиллах талаар зөвлөмж байдаггүй.

Social Monitoring Судалгааны төв “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал” судалгааны фокус бүлгийн ярилцлагын дүнгээс...

Хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт

56. Үндэсний Статистикийн Газрын хийсэн судалгаагаар 15 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 26.4 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Тэдгээр иргэдийн 56.9 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 16.4 хувь нь гэр бүлийн бизнест оролцогч, 12.8 хувь нь гэрээгээр ажиллагч байна²². Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үүднээс төрийн, төрийн бус, олон улсын байгууллагуудын зүгээс нэлээд ажлыг зохиох болсон нь тодорхой хэмжээгээр үр дүнгээ өгч байна. Тухайлбал, 2006 онд Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Газар 555 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын, 125 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг түр ажлын байраар хангаж, 11 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 1-10 сая хүртэлх төгрөгийн зээл олгон, 25 ажлын байрыг шинээр бий болгон ажиллахад дэмжлэг үзүүлжээ. Түүнчлэн, мэргэжил олгох сургалтанд 479 иргэнийг хамруулсан байна²³. 2002-2004 оны хооронд хэрэгжсэн “Тахир дутуу иргэдийн хөдөлмөр

²² Үндэсний Статистикийн Газар, “Тахир дутуу иргэдийн нэг удаагийн бүртгэл” түүвэр судалгаа, 2004 он

²³ Хөдөлмөрийн зах зээлийн 2005 оны жилийн эцсийн тайлан Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яам, 2006 он

эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл"-ийн хүрээнд 1677 хүнийг ажлын байранд зуучилж, 825 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг 40 гаруй мэргэжлээр сургаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 136 аж ахуйн нэгж, бүлэг хүмүүст 62360 ам.доллар, хувиараа бизнес эрхлэгч 140 хүнд 33820 ам.долларын дэмжлэг үзүүлж чадсан байна.

57. Гэсэн хэдий боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд орчны саад, олон нийтийн ойлголт, хандлага болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрсдийн идэвхи санаачлага, хандлагатай холбоотой тааламжгүй асуудлууд цөөнгүй байна. Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Чөлөөт Үйлдвэрчний Эвлэлээс 2006 онд хийсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрх” судалгаагаар хөдөлмөр эрхэлж буй 832 хүн, хөдөлмөр эрхлэх сонирхолтой 316 хүн, нийт 1148 хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс авсан санал асуулгаар тэдгээр иргэд хөдөлмөр эрхлэхэд нь учирч буй хүндрэл бэрхшээлийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө хуулиа мэддэггүй, хөдөлмөр эрхлэх сонирхолтой боловч эрүүл мэндийн шалтгаанаар ажлын цаг баримтлах боломжгүй, ажил олгогч нар хүлээж авдаггүй, ихэвчлэн цалин багатай туслах ажил хийдэг учраас тогтвортой ажиллаж чаддаггүй гэж тодорхойлсон байна.

58. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийн тулд ажил олгогчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэр бүлийнхэн болон нийгмийн сэтгэл зүйн эерэг хандлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. АЙФО байгууллагын хийсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд хийгдсэн судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 40 гаруй хувь нь өөрсдийгөө ажил хөдөлмөр эрхлэхэд хүндрэл, бэрхшээл байхгүй гэсэн байхад тэдгээр иргэдийн асран хамгаалагчдын 25 хувь нь, албан хаагчдын ердөө 5.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хөдөлмөр эрхлэх байдлаар нийгмийн идэвхтэй үйл ажиллагаанд оролцоход хүндрэл гарахгүй гэж хариулсан байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй

иргэдийн хөдөлмөрийн чадварын талаарх эрүүл хүмүүсийн ойлголт төсөөлөл төдийлөн сайнгүй байгааг харуулж байна.

...Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны иргэн, одой “Ж.Б” нь 1999 онд Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургуулийг В үнэлгээтэйгээр төгссөн, 2001 онд компьютерийн нэг жилийн курс төгссөн боловч ажилд ороход хүндрэлтэй байна.

Тэрээр “Би олон газар ажил хайж очсон. Сонин, телевизийн зараар анкет, дипломын хуулбараа өгөхөд ярилцлагад оруулна гэдэг. Гэхдээ уулзчихаад, гол нь намайг харчихаад “бид эрэгтэй хүн авна”, “бидэнд арай өөр хүн хэрэгтэй”, “чам уруу эргээд ярина” гэж хэлээд авдаггүй.

ХЭҮК-оос 2003 онд хийсэн “Тахир дутуу иргэдийн эрхийн төлөв байдал” судалгааны материалаас...

59. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа 3, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг авч ажиллуулах тухай заалтыг төв, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжүүд тун хангалтгүй биелүүлж байна. 2006 онд Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Чөлөөт Үйлдвэрчний Эвлэлээс хийсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрх” судалгаанд нийслэлийн 9 дүүргийн 50 ба түүнээс дээш ажилтантай 521 аж ахуйн нэгж, байгууллага хамрагджээ. Хуульд заасны дагуу эдгээр байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллавал зохих 2486 ажлын байрны 58.3 хувьд нь буюу 1450 орон тоон дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байна. Түүнчлэн, тус судалгаанд 7 аймгийн 164 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан бөгөөд тэдгээр байгууллагад нийт 784 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж болохуйц орон тоо байгаагийн 63.2 хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байна. Хуулиар тогтоосон

хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллуулаагүйн нөхөн төлбөрийг байгууллагууд тэр бүр бүрэн гүйцэд төлөхгүй байна. Уг судалгаанд хамрагдсан 685 аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөрийн улсын байцаагчийн шаадлагаар нийт 9.042 мянган төгрөгийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн санд нөхөн оруулахаар болсон байна.

60. Хуулийн дээрх заалт хэрэгжихгүй байгаагийн өөр нэг шалтгаан бол хөдөө, орон нутгийн хувьд 50 ба түүнээс дээш ажилтантай байгууллагууд нь ихэвчлэн эмнэлэг, сургууль, тамгын газар, цагдаа зэрэг төсвийн байгууллага байгаатай холбоотой байна. Хөдөө, орон нутгийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд нь ихэвчлэн маш цомхон бүтэцтэй, хамгийн ихдээ 25 орчим хүний орон тоотой байна. Мөн хууль сахиулах болон батлан хамгаалах байгууллагын удирдах албан тушаалтнуудын зүгээс Хөдөлмөрийн тухай хуулийн дээрх зүйл, заалтыг биелүүлэхээс цааргалж байсныг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрх” судалгааны тайланд дурджээ.

...Төв аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга “Э” нь “Энэ хуулийн заалт Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуультай зөрчилддөг. Цагдаагийн ажилтнууд бэлтгэгдсэн, өндөр шаардлага тавигддаг, төрийн тусгай албан хаагчид байдаг учраас энд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг авч ажиллуулах боломжгүй. Нөхөн төлбөр төлөх тухайд төсөв хүрэлцдэггүй тул төлж чадахгүй. Цаашид төрийн тусгай албадын хувьд энэ хуулийн үйлчлэлийг хязгаартай байлгах талаар холбогдох эрх бүхий байгууллагад нь дамжуулаарай” гэж байлаа.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрх” судалгааны тайлангаас...

Сэтгэцийн өвчтэй хүмүүсийн эрхийн хэрэгжилт

61. Хүний Эрхийн Үндэсний Комиссоос сэтгэцийн өвчтэй хүмүүсийн эмнэлгийн тусламж авах эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг тодорхойлох үүднээс Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн стационарийн үйл ажиллагаанд шалгалт хийлээ. Эрүүл мэндийн сайдын 2006 оны 331 дүгээр тушаалаар Сэтгэцийн Клиникийн Эмнэлэг, Наркологийн Үндэсний Төвийг нэгтгэн Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийг байгуулжээ. Тус төв нь 450 ортой, 437 эмч ажиллагсадтай, өвчтөнийг хэвтүүлж эмчлэх 11 тасаг, эмчилгээ, үйлчилгээний 20 нэгжтэй үйл ажиллагаа явуулж байна.

62. Шалгалт хийх үеийн байдлаар тус төвд нийт 427 өвчтөн хэвтэж эмчлүүлж байлаа. Нийт өвчтөнүүдийн 241 буюу 56.4 хувь нь асран хамгаалах, харгалзан дэмжих хүнгүй буюу ар гэр нь асран тэтгэхээс зайлсхийсэн, 3 сараас дээш хугацаагаар хэвтэж буй сэтгэцийн архаг өвчтөнүүд байна. Эдгээр өвчтөний хэвтсэн хугацааг судлахад 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар 40 буюу 16.59 хувь нь, 1 жил 1 сараас 3 жил хүртэлх хугацаагаар 130 буюу 53.94 хувь нь, 3 жил 1 сараас 5 жил хүртэлх хугацаагаар 27 буюу 11.2 хувь нь, 5 жил 1 сараас дээш хугацаагаар 44 буюу 18.25 хувь нь тус төвд “байнга” амьдарч байна. 144 өвчтөнийг гэр орон нь огт авдаггүй ажээ.

63. 2003 онд Мааньт дахь Сэтгэцийн өвчтэй хүмүүсийн улсын асрамжийн газар татан буугдаж 183 хүн Сэтгэцийн Клиникийн Эмнэлэгт шилжиж ирснээр тус эмнэлгийн ачаалал ихэсч, “хагас асрамжийн газар”-ын үйл ажиллагаа явуулах болжээ. Түүнчлэн, 2006 онд Эрүүл Мэндийн сайдын тушаалаар Наркологийн Үндэсний Төвийг тус эмнэлэгтэй нэгтгэж, 100 гаруй ажилтан, ажиллагсадтай байгууллага Сэтгэцийн Клиникийн Эмнэлгийн байранд ажиллах болсон нь Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвд эмчлүүлэгсдийн эрх зөрчигдөх үндсэн шалтгаан болж байна.

64. Тус төвд эмчлүүлэгсдийн орон байрны нөхцөл муу, нэг өвчтөнд оногдох талбайн хэмжээ стандартад зааснаас 2-3 дахин бага байгаа юм. “Төрөлжсөн нарийн мэргэжлийн

эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5203:2002 стандартад заасны дагуу насанд хүрсэн нэг өвчтөнд 7 м², хүүхдэд 6 м² талбай ноогдох ёстой байхад тус төвийн насанд хүрсэн өвчтөнд дунджаар 2.4-3 м² талбай, насанд хүрээгүй өвчтөнд 3.8 м² талбай оногдож байна. Зарим тасгуудын хонгил, коридорт, эсхүл нэг орон дээр хоёр өвчтөн хэвтүүлж байгаа бөгөөд эмнэлгийн ачаалал ихэдсэн тохиолдолд өвчтөнийг гудас засч наарлан хэвтүүлдэг байна.

65. Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн барилга байгууламж, сантехникийн шугам хуучирч муудсан, өрөөний тааз, хана мөөгөнцөртсөн, чийгшил ихтэй, агааржуулалт муу, нэг өрөөнд хэт олон хүн хэвтэж байгаа зэрэг нь халдварт өвчин тархах нөхцлийг бүрдүүлж байна. Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвд хэвтэж эмчлүүлэгчдийн дийлэнх нь сүрьеэ өвчтэй байгаа бөгөөд шалгалт хийх үеийн байдлаар уг өвчин нь хурц үедээ байгаа 19 өвчтөн ямар нэг тусгаарлалгүй бусад өвчтөнүүдтэй хамт эмчлүүлж байлаа. Мөн хамуу зэрэг арьсны өвчин тус төвийн үйлчлүүлэгчдэд тархаж байна. Сүрьеэ өвчнөөр өвчтөнүүд төдийгүй эмнэлгийн эмч, ажилтнууд халдварлах тохиолдол цөөнгүй гарч байна. Тухайлбал, 2006 онд тус төвийн зөвхөн нэг тасгийн 3 эмч сүрьеэ өвчнөөр өвдсөнөөс нэг нь хөдөлмөрийн чадвараа алдаж байжээ.

66. Тус төвийн өвчтөнүүд чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх, мэдээлэл хүлээн авах боломж хязгаарлагдмал байна. Хэдийгээр өвчтөнүүдийн талаас илүү хувь нь тэндээ байнга амьдарч байгаа боловч тасгуудад чөлөөт цагаа өнгөрүүлэхэд шаардлагатай тоглоом наадгай, ном, сонин сэтгүүл хангалтгүй, харилцаа холбоо, шуудангийн үйлчилгээ авч чадахгүй байна.

67. Эмчилгээнд хэрэглэж буй сэтгэцэд нөлөөлөх эмийн талаар зарим асуудал анхаарал татаж байна. Тухайлбал, Эрүүл Мэнд, Нийгмийн Хамгааллын сайдын 2000 оны 210 дугаар тушаалын дагуу манай улсад сэтгэцэд нөлөөлөх 11 төрлийн эм хэрэглэж байгаа бөгөөд эдгээр эм бэлдмэлүүдээс аминазин, галиоперидол зэрэг зарим эм гаж нөлөө ихтэй, үйлчилгээний үр дүн тааруу, дэлхийн улс орнуудад хэрэглэхээс

аль болох татгалзах болсон байна. Аминазин, галиоперидол зэрэг эмээс давуу үйлчилгээтэй зуклопентиксол, галоперидол-деконат зэрэг шинэ төрлийн зөвшөөрөгдсөн эмийг эмчилгээнд хэрэглэж болох боловч өндөр өртөгтэй учраас нэг өвчтөний хоногийн эм, тарианы төсөв хүрдэггүй ажээ. Түүнчлэн, сүүлийн жилүүдэд эмийн жагсаалтанд оруулсан шинэ эм, тариаг ханган нийлүүлэгч олдохгүй байгаа нь эмчилгээ, үйлчилгээнд бэрхшээл учруулж байна. Жишээлбэл, зуклопентиксол, галоперидол-деконат зэрэг эмийг авахаар 2005 онд тендерийн саналд оруулсан боловч одоог хүртэл нийлүүлэлт хийх байгууллага олдохгүй байгаа ажээ.

68. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т “Эмнэлэгт албадан эмчлүүлсэн, нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн өвчтэй хүний сэтгэцийн байдал албадан эмчлэх өвчний заалттай тохирч байгаа эсэхийг өвчтөнийг эмнэлэгт хэвтсэнээс хойш 72 цагийн дотор тусгай комисс магадлан тогтооно” гэж заасны дагуу тус төвийн ерөнхий захирлын 2007 оны 42 дугаар тушаалаар тус төвийн магадлан тогтоох комиссыг байгуулсан боловч огт үйл ажиллагаа явуулахгүй байна. Магадлан тогтоох комиссын бүрэлдэхүүнд орсон эмч ажилтнууд энэ тухайгаа мэдээгүй, комисс байгуулагдсанаас хойш нэг ч удаа магадлан тогтоох үйл ажиллагаа явуулаагүй байгаа нь хүний халдашгүй дархан байх эрх зөрчигдөх эрсдлийг бий болгож байна.

69. Эрүүл Мэнд, Нийгмийн Хамгааллын сайдын 2000 оны 210 дугаар тушаал болон төвийн ерөнхий захирлын 2007 оны 42 дугаар тушаалаар сэтгэцийн өвчтэй хүнийг номхотгох дөрвөн төрлийн аргыг тодорхойлж, хэрэгжүүлэх журмыг тогтоожээ. Эдгээр эрх зүйн актуудад заасны дагуу нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн өвчтэй хүнд урьдчилан сэргийлэх зорилгоор дараах аргуудыг хэрэглэж болно. Үүнд:

- Өвчтөнийг төмөр орон дээр хэвтүүлж, хөнжлөөр өлгийдөх арга
- Өвчтөнийг орон дээр хэвтүүлж, цээж ба өвдгөн тус газар нь боолт хийх арга

- Өвчтөнийг дамнуурган дээр хэвтүүлж, цээж ба өвдгөн тус газар нь боолт хийх арга
- Өвчтөнийг дамнуурган дээр хэвтүүлж, хөнжлөөр өлгийдөх арга зэрэг болно. Гэвч тус төвд огт зөвшөөрөгдөөгүй арга буюу их биеийн ямар нэг ороолт, боолтгүйгээр өвчтөний 2 гарыг зөөлөн даруулгаар төмөр ортой хүлж бэхлэх аргыг түгээмэл хэрэглэж байгаа нь дээр дурдсан актуудад нийцэхгүй байна.

70. Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвд удаан хугацаагаар хэвтэж эмчлүүлж байгаа 44 өвчтөн нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжид хамрагдаж чадаагүй, 45 өвчтөн иргэний үнэмлэхгүй байна.

71. Тус төвийн хүүхдийн тасагт нийт 26 өвчтөн эмчлүүлж байгаагийн 13 нь эрэгтэй, 13 нь эмэгтэй байгаа бөгөөд 19 хүүхэд нь тус төвд байнга амьдарч, асруулдаг байна. Эдгээр 19 хүүхэд ямар ч төрсний гэрчилгээ, бичиг баримтгүй байна. Төрийн хяналт, иргэний бүртгэлээс гадуур байгаа нь хүүхдийн эрх ноцтой зөрчигдөж болзошгүй эрсдлийг бий болгож байгаа юм.

72. Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн эмч, ажилтнуудын цалин хөлсний нэмэгдэл, урамшуулал нь гүйцэтгэдэг ажил үүрэг, ажиллах орчны онцлогтой нь харьцуулахад хангалтгүй байна. Тухайлбал, эмч, ажилтнууд хамтын гэрээнийхээ дагуу хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласны 7000 төгрөгийн нэмэгдэл авч байгаа юм. Эмч, ажилтнууд өвчтөндөө цохиулах, гэмтэл авах тохиолдол түгээмэл байдаг бөгөөд сүүлийн 3 жилд зөвхөн 3 дугаар тасгаас 12 ажилтан хүнд, хүндэвтэр гэмтэл авч байжээ. Иймээс эмч, ажилтнуудын аюулгүй байдлыг хангахад анхаарал хандуулах шаардлагатай байна.

МОНГОЛ
СУДАЛГААНЫ САН

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хүний эрхийн боловсролын талаарх дэлхий нийтийн чиг хандлага

1. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 26 дугаар зүйлийн 26.2-т “Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход чиглэх ёстой. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биенээ харилцан ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн, НҮБ-аас энх тайвныг сахиулах талаар явуулж буй үйл ажиллагаанд тус дөхөм үзүүлэх ёстой” хэмээн боловсролын зорилгыг нэн оновчтой тодорхойлжээ. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын энэхүү үзэл санааг НҮБ-аас батлан гаргасан хүний эрхийн бусад суурь гэрээ, конвенциор баталгаажуулсан байдаг. Тухайлбал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 13 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн конвенцийн 29 дүгээр зүйл, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцийн 10 дугаар зүйл, Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцийн 7 дугаар зүйлд хүний сурч боловсрох эрхийг баталгаажуулж, иргэд энэ эрхээ эдлэх нөхцөл бололцоог бий болгох төрийн үүргийг тодорхойлсон байна.

2. Хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор НҮБ болон бусад олон улсын байгууллагуудаас олон чухал арга хэмжээ зохион байгуулж, нэлээд олон тооны хөтөлбөр, зарчим, тунхаглалыг батлан гаргасан юм. Тухайлбал, 1993 оны Венийн тунхаглал ба үйл ажиллагааны хөтөлбөр²⁴, 2001 онд Өмнөд Африкийн Дурбан хотноо хуралдсан Арьсны үзэл, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах ксенофоби болон бусад үзлийн эсрэг Дэлхийн чуулга уулзалтын тунхаглал, үйл

²⁴ 1 дүгээр хэсгийн 33,34 ба 2 дугаар хэсгийн 78-82 дугаар зүйлүүд

ажиллагааны хөтөлбөр зэргийг дурдаж болно. Түүнчлэн, 1993 онд Монреал хотноо зохион байгуулагдсан олон улсын их хурлаас баталсан “Хүний эрх ба ардчиллын тухай боловсролын дэлхийн хөтөлбөр”, 1994 оны Боловсролын олон улсын бага хурлаас гаргасан “Энх тайван, хүний эрх ба ардчиллын талаарх тунхаглал ба хамтын үйл ажиллагааны үндэс суурь” баримт бичиг, 1995 оны ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлаар баталсан “Хүлээцтэй хандах тухай тунхаглал”, 1995 оны “Боловсрол-Бүх нийтэд” Дакарын тунхаглал зэрэг баримт бичгүүд батлагдан гарчээ.

3. НҮБ-ын Ерөнхий Ассемблей 1995-2004 оныг “Хүний эрхийн боловсролын НҮБ-ын 10 жил” болгон зарлаж, уг арван жилийн хугацаанд улс орон бүр хүний эрхийн боловсролын үндэсний хэмжээний үр дүнтэй, тогтвортой стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллажээ. 2004 онд НҮБ-аас Хүний эрхийн боловсролын 10 жилийн үр дүнд үнэлгээ хийсэн юм. Хэдийгээр 1995-2004 онд дэлхий нийт, бүс нутаг, улс орон бүр хүний эрхийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэхэд хүчин чармайлт гаргаж, ололт амжилтанд хүрсэн боловч энэ ажлыг цаашид ч үргэлжлүүлэх шаардлагатай байгаа нь НҮБ-ын хийсэн үнэлгээнээс харагдсан байна. Иймд 2004 онд НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 59 дүгээр чуулганы хуралдаанаас “Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр”-ийг баталж, 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр болжээ.

4. “Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр”-т дэвшүүлтэвсэнтэргүүний зорилт бол 2005-2007 онд багтаан улс орон бүр ерөнхий боловсролын сургуулийн тогтолцоонд хүний эрхийн боловсрол олгож буй үйл ажиллагаандаа үнэлгээ хийх, үнэлгээндээ тулгуурлан хүний эрхийн боловсролын талаар хөтөлбөр боловсруулах, хүний эрхийн сургагч багш нарыг бэлтгэх явдал юм.

Хүний эрхийн боловсролын талаарх Монгол Улсын хууль тогтоомж, төрийн бодлого

5. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.7-д “иргэн нь сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно”, Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “...иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох нөхцлөөр хангана” гэж заасан байдаг.

6. Монгол Улсын иргэн сурч боловсрох эрхээ эдлэх орчин нөхцлийг бүрдүүлэх, боловсролын зарчим, агуулга, зорилгыг тогтоох үүднээс Улсын Их Хурлаас төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (1995)-ыг тодорхойлж, Боловсролын тухай (2002), Бага, дунд боловсролын тухай (2002) болон Дээд боловсролын тухай (2002) зэрэг хуулиудыг тус тус батлан гаргажээ. Боловсролын удирдлага, санхүүжилтийн төвлөрлийг сааруулах, сургуулийн менежментийг аймаг, орон нутгийн удирдлагад шилжүүлэх, их, дээд сургууль, коллежуудын бие даасан байдлыг хангах, хувийн өмчийн боловсролын байгууллага байгуулахад дэмжлэг үзүүлэх болон боловсрол нь нээлттэй, хүртээмжтэй байх бодлогыг дээрх хууль тогтоомжид тусгасны дүнд хувийн өмчийн сургууль олноор байгуулагдаж, өрсөлдөөний үндсэн дээр боловсролын салбарт чанарын ахиц гарч байна.

7. Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр (2003)-ийн 1.1.2.6-д “Хүний эрхийн боловсролын төлөв байдал, хэрэгцээ шаардлага, хамрах хүрээг судалсны үндсэн дээр ... хүний эрхийн албан ба албан бус сургалтын тогтолцоог бүрдүүлж, энэ асуудлаар үндэсний мэргэжилтэн, сургагчдыг бэлтгэх дэд хөтөлбөр гарган хэрэгжүүлнэ” хэмээн заажээ. Уг хөтөлбөр батлагдсанаас хойш 4 жил өнгөрч байгаа боловч хүний эрхийн боловсролын хэрэгцээ, төлөв байдлыг тодорхойлох судалгаа хийгдээгүй, дэд хөтөлбөрийг боловсруулаагүй

байна. Ийм нөхцөл байдал нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлээгүй, механизмыг цаг тухайд нь тодорхойлж чадаагүйтэй холбоотой байна. Харин Засгийн газрын 2007 оны 17 дугаар тогтоолоор “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2007-2008 оны төлөвлөгөө”-г баталж, хүний эрхийн албан ба албан бус сургалтын тогтолцооны загвар боловсруулж, хүний эрхийн мэргэшсэн сургагч багш нарыг бэлтгэх дэд хөтөлбөр боловсруулж ажиллахыг Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яаманд даалгажээ. Гэхдээ уг ажлыг зохион байгуулах хөрөнгийг улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилтээс гаргахаар заасан нь тодорхой биш байгаа бөгөөд төлөвлөгдсөн ажил цалгардах, орхигдох нөхцөл байдлыг үүсгэж болзошгүй байгааг холбогдох эрх бүхий байгууллагууд анхааралдаа авах шаардлагатай байна.

Хүний эрхийн боловсролын хэрэгцээ, шаардлага

8. Иргэдийн хүний эрх, эрх зүйн боловсролын түвшин, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор төрийн ба төрийн бус байгууллагуудаас нэлээд олон тооны судалгаа хийсэн байна. Тухайлбал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, туслалцааны хүртээмжтэй байдал” (2005), Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн нийгмийн ухааны тэнхимийн “Монгол дахь хүний эрхийн боловсрол ба соёлын харьцангуй чанар” (2005), Хууль Зүйн Үндэсний Төвийн “Иргэдийн эрх зүйн албан бус боловсролын эрэлт хэрэгцээний судалгаа” (2005), АНУ-ын Азийн сангийн “Эрх зүйн гэгээрэл-Монгол Улсад” (2004) зэрэг судалгааг дурдаж болно. Эдгээр судалгааны үр дүнгээс иргэдийн дийлэнх нь хүний эрх, эрх зүйн боловсролын ач холбогдлыг мэдэж байгаа боловч хүний эрхийн талаар цогц мэдлэг ойлголтгүй, эрх, эрх чөлөөгөө хамгаалах чадвар дутмаг байгааг тогтоожээ. Дээрх судалгаануудад иргэдийн ихэнх нь эрх, эрх чөлөө нь зөрчигдсөний дараа л хүний эрхийн боловсрол чухал болохыг ойлгодог талаар дурдсан нь анхаарал татаж байна.

Албан боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсрол

9. 2006-2007 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсрол олгох 742 байгууллагад 94.7 мянга, төрийн ба хувийн өмчийн 706 ерөнхий боловсролын сургуульд 542.5 мянга, 41 мэргэжлийн боловсролын байгууллагуудад 24.7 мянга, төрийн болон хувийн өмчийн 164 их, дээд сургууль, коллежид 142.4 мянган суралцагч хамрагдаж байна. Энэ нь манай улсын нийт хүн амын 30 гаруй хувийг эзэлж байгаа юм. Албан боловсролд хамрагдагсдын тоо ийм өндөр үзүүлэлттэй байгаа нь хүний эрхийн боловсролыг ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллежийн өнөөгийн тогтолцоонд түшиглэн олгох боломжтойг харуулж байна.

10. 1998-2003 онд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам, Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэнгээс хамтран хэрэгжүүлсэн “Хууль бидний амьдралд” хөтөлбөр нь орчин үеийн шаардлагад нийцсэн хүний эрхийн боловсролыг ерөнхий боловсролын сургалтанд нэвтрүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан юм. Хөтөлбөрийн үр дүнд ерөнхий боловсролын сургуулийн эрх зүйн хичээлийн агуулга, хэрэглэгдэхүүн, арга зүйг цогц байдлаар боловсруулж, дунд сургуулиудад хүний эрх сэдвээр бие даасан хичээл орох болсон байна.

11. 2004 онд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамнаас “Бага, дунд боловсролын стандарт”-ыг шинэчлэн баталсан бөгөөд уг стандартын бүрэлдэхүүн хэсэг болох “Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт”-д суралцагчдад хүний эрхийн тухай мэдлэг, эрхээ эдэлж, зөрчигдсөн эрхээ хамгаалах чадвар олгох болон хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх хандлага төлөвшүүлэх зорилтыг дэвшүүлэн тавьжээ. Түүнчлэн, арван хоёр жилийн сургалтын тогтолцоонд шилжих бэлтгэл ажлын хүрээнд Сургалтын төлөвлөгөө, хичээлийн агуулгын үлгэрчилсэн хүрээг турших тухай Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын 2004 оны 132 дугаар тушаалд ерөнхий боловсролын сургуулийн “Хүн ба нийгэм”, “Иргэншил”, “Иргэн ба нийгэм” зэрэг хичээлийн хүрээнд хүний эрх, эрх зүйн тухай

мэдлэг, ойлголтыг 1-11 дүгээр ангиудад тус бүр судлахаар заасан байна. Үүний зэрэгцээ дээрх тушаалд сурагчид хичээлээс гадуурх ажлын хүрээнд “Иргэний боловсрол” хичээлийг судлахаар тусгасан нь хүний эрхийн боловсролыг түгээхэд ач холбогдолтой болсон байна.

12. Хүний эрхийн боловсролыг ерөнхий боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх талаар төрөөс дээр дурдсан болон бусад арга хэмжээ авч байгаа боловч бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөр нь шилжилтийн, туршилтын гэх байдлаар олон удаа өөрчлөгдөж, тогтворжихгүй байгаа дутагдал байна.

13. 2005 онд Хүний Эрхийн Үндэсний Комиссоос ЮНЕСКО-гийн дэмжлэгтэй “Хүний эрхийн боловсрол-Ерөнхий боловсролын сургуульд” судалгааны ажлыг хийж, ерөнхий боловсролын сургуульд судалж буй “Хүний эрх” хичээлийн чанар, үр нөлөө, сургалтын агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, багшлах боловсон хүчний болон сургуулийн хүний эрхийн орчин нөхцлийн талаар үнэлгээ хийсэн болно. Уг судалгаанд Архангай, Баян-Өлгий, Дархан-Уул, Өмнөговь, Сүхбаатар, Ховд зэрэг аймаг, нийслэлийн 6 дүүргийн нийт 175 сургууль хамрагдсан.

14. Судалгаа хийх үед мөрдөж байсан боловсролын стандарт болон Гэгээрлийн сайдын 1998 оны 100 дугаар тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу хүний эрхийн хичээлийг 6 дугаар ангид хувьсах болон тогтвортой агуулгаар судлахаар тогтоосон байв. Гэвч Улаанбаатар хотын Баянгол, Сонгинохайрхан дүүргийн хувийн өмчийн 13 сургуульд “Хүний эрх” хичээл огт ордоггүй, бусад сургуулиудын хувьд 31 сургуульд 9 цагаар, 37 сургуульд 18 цагаар, 38 сургуульд 27 цагаар тус тус орж байсан байна. Ийнхүү сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан “Хүний эрх” хичээлийг зарим сургуулиуд огт ордоггүй, зарим сургуулиуд хэт цөөн цагаар орж байсан нь сурагчдад хүний эрхийн цогц мэдлэг, чадвар, хандлага төлөвшиж чадахгүйд хүргэж байна.

15. Хүний эрхийн сургалтын чанар, үр дүнд багш нарын заах арга зүй хоцрогдсон, сургуулийн удирдлагаас мэргэжил, арга зүйн туслалцаа хангалттай үзүүлж чаддаггүй, нэг ангид

суралцаж буй сурагчдын тоо хэт олон, ном, сурах бичгийн хүртээмж муу байгаа зэрэг нь сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, судалгааны хүрээнд нийтдээ 29 багшийн хичээлд сууж анализ хийхэд хангалттай 5 буюу 17.2 хувь, дунд 17 буюу 58.6 хувь, хангалтгүй 7 буюу 24.1 хувийн үзүүлэлттэй хичээл заагджээ. Түүнчлэн, уг судалгаагаар ерөнхий боловсролын сургуулиудын номын санд байгаа хүний эрхийн холбогдолтой ном, гарын авлагын хүртээмж, хангалтанд ажиглалт хийсэн. Судалгаанд хамрагдсан нийт сургуулиудын 67.5 хувь нь сурах бичгээс өөр хүний эрх, эрх зүйн чиглэлийн ном, гарын авлагаар хангагдаагүй байна.

16. Ерөнхий боловсролын түвшинд хүний эрхийн хичээлийн хөтөлбөр, агуулгыг шинэчлэн тогтоосон боловч тухайн хичээлийг заах багшийг бэлтгэх, давтан сургах ажил удаашралтай байна. Хүний эрхийн хичээлийг тухайн чиглэлээр мэргэшээгүй, өөр мэргэжлийн багш нар заах явдал нийтлэг байгаагаас хичээлийн ач холбогдол буурч, хэлбэрийн төдий сургалт явагдаж байна. Судалгаагаар хүний эрх хичээлийг зааж буй багш нарын нийтлэг бэрхшээлийг багшийн ном байдаггүй, сургалтын хэрэглэгдэхүүн хомс, хүний эрхийн талаар нарийн мэдлэггүй, нэмэлт мэдээлэл авах бололцоо муу, сурагчдын тоо хэт олон, бусад багш нар төдийгүй сургуулийн удирдлагууд хүний эрхийн хичээлийн ач холбогдлыг ойлгодоггүй гэж тодорхойлсон байна.

17. Хүн өөрийн хүрээлэн буй орчноос ихийг сурч мэддэг ба тухайн хүний зан төлөв ч орчноосоо хамааран төлөвшдөг тул сургуулийн хүний эрхийн орчин нь боловсролын тогтолцооны үнэт зүйл байх ёстой. Сургуульд хүний эрхийн орчин бүрдээгүй нөхцөлд хүний эрхийн хичээл заагаад ч бодитой үр дүн гарч чадахгүй билээ. Хүний Эрхийн Үндэсний Комиссын судалгааны дүнгээс ерөнхий боловсролын сургуулиудад хүний эрхийн орчин бүрдэж чадаагүй байгаа нь харагдаж байна. Ялангуяа, сургуулийн удирдлага, багш нарын зүгээс сурагчдад нэр хоч өгөх, үг хэлээр доромжлох, хүч хэрэглэх, ялгаварлан гадуурхах, сурагчдын үзэл бодлыг үл хүндэтгэх зэрэг зөрчил түгээмэл гарч байна.

... “Н” багш монгол хэлний сумын олимпиадад надаас их алдсан хүүхдэд хүрэл медаль өгсөн байсан. Энд би их гомдсон боловч хаана хандахаа мэдээгүй. Урам их хугарсан. Хичээлийн эрхлэгчид хэлсэн боловч өнгөрсөн хойно нь хэл ам таталлаа гэсэн.

... Багш нар зарим зүйл дээр илт ялгаварладаг. Жишээ нь, сайн сурдаг хүүхдээ илүү анхаарч, дандаа өргөдөг, чадлаараа хийсэн хүүхдийг дэмждэггүй. Хамаг анхаарлаа сайн хүүхдэдээ тавьж, тэднийг олимпиад тэмцээнд бэлддэг.

... Багш нар дарамталдаг, нэр хоч өгдөг. Жишээ нь, толгойг чинь цоо цохиод, нусыг чинь суга алгадаад, цонхоор шиднэ шүү гэж загнадаг.

*Судалгааны үеэр сурагчидтай
ярилцсан тэмдэглэлээс...*

18. Хүний Эрхийн Үндэсний Комиссоос уг судалгааны үр дүнд тулгуурлан “Хүний эрх” хичээлийг заах багш нарт тавигдах шаардлага, Улсын Их Хурал, Засгийн газар, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам, Улсын Мэргэжлийн Хяналтын Газар, Боловсролын Хүрээлэн, Аймаг, Нийслэлийн Боловсрол, Соёлын Газар, багш бэлтгэдэг их, дээд сургуулиуд болон ерөнхий боловсролын сургуулиудад хандсан зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн юм.

19. Их, дээд сургуулийн ялангуяа, эрх зүйч, төрийн захиргааны албан хаагчдыг бэлтгэж буй сургуулиудын сургалтын хөтөлбөрт хүний эрхийн хичээлийг заавал судлах хичээл болгон оруулах, хүний эрхийн мэдрэмжтэй төрийн албан хаагчдыг бэлтгэн гаргах шаардлагатай байна. Гэгээрлийн сайд, Хууль Зүйн сайдын хамтарсан 1997 оны 230/200 дугаар тушаалын дагуу эрх зүйч мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудад хүний эрхийн хичээлийг 36 цаг үзэхээр заасан байдаг. 2003 онд Хүний Эрхийн Үндэсний Комиссоос эрх зүйн боловсрол олгож буй их, дээд сургуулиудад хүний эрхийн хичээлийг хэрхэн зааж буй байдалд үнэлгээ хийхэд цөөн тооны сургуулиуд хүний эрхийн хичээлийг заавал үзэхээр, ихэнх сургуулиуд сонгон суралцах байдлаар үзэхээр сургалтын

төлөвлөгөөнд заасан байв. Бусад их, дээд сургуулиудад эрх зүйн хичээлийн цагт хүний эрхийн хичээлийг хамтатган үзэж байсан нь үнэлгээний дүнгээс харагдаж байна.

20. 2003 онд Хүний Эрхийн Үндэсний Комисс нь эрх зүйн боловсрол олгодог их, дээд сургуулиудын хүний эрхийн хичээлийн загвар хөтөлбөрийг боловсруулсан. Энэ ажлын хүрээнд 2 кредит цагаар судлах “Хүний эрх” хичээлийн загвар хөтөлбөрийг боловсруулах, агуулга, арга зүйг нь тодорхойлох, хууль зүйн их, дээд сургуулиудад түгээх, сургалтанд нэвтрүүлэх, их, дээд сургуулийн багш нарыг сургах зэрэг ажлуудыг зохион байгуулсан нь үр дүнтэй болсон юм. Гэвч энэхүү загвар хөтөлбөрийг боловсруулах зорилгоор хууль зүйн их, дээд сургуулиудын хүний эрхийн хичээлийн хөтөлбөртэй танилцах хүсэлт тавихад олонх сургуулиудад ийм хөтөлбөр байхгүй эсхүл олдохгүй байна гэж байсан нь хүний эрхийн боловсролд хэрхэн анхаарч байгаагийн илэрхийлэл гэж үзэж байна.

21. Багш бэлтгэх, давтан сургах их, дээд сургуульд хүний эрхийн хичээл үздэг байх нь хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх олон чухал асуудлыг шийдвэрлэх ач холбогдолтой юм. 2004-2005 оны хичээлийн жилээс эхлэн Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн эрх зүй, нийгмийн ухаан, түүхийн багшийн ангиудад “Хүний эрхийн боловсрол” хичээлийг сонгон суралцах хэлбэрээр судалж эхэлжээ. Түүнчлэн, 2006 оноос тус сургууль нь дэргэдээ “Хүний эрхийн боловсролын төв”-ийг нээн ажиллуулж, хүний эрхийн сургагч багш бэлтгэх, сургалтын материал боловсруулах, хүний эрхийн мэдээлэл, сургалтын интернэт хуудас²⁵ ажиллуулах зэрэг олон ажил хийж байна. Манай улсын багш бэлтгэх тогтолцооны цөм болсон Монгол Улсын Боловсролын Их Сургууль ийнхүү хүний эрхийн боловсролын асуудалд анхаарч, уг санаачлагыг НҮБ-ын Хүүхдийн сан, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамнаас дэмжиж байгаа нь сайшаалтай байна.

22. Хэдийгээр дээр дурдсан нааштай алхмууд хийгдэж байгаа боловч хүний эрхийн боловсролыг албан боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх ажил нийтийг хамарч чадахгүй,

²⁵ www.humanrights.org.mn

хязгаарлагдмал хүрээнд явагдаж байна. Ялангуяа, мэргэжлийн болон дээд боловсролын түвшинд хүний эрхийн боловсрол олгох нэгдсэн бодлого үгүйлэгдэж байна. Иймд хүний эрхийн боловсролыг дээд боловсролын стандартад тусган эрх зүйч, багш, эмч, төрийн захиргаа, удирдлагын мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуульд заавал үзэх, бусад дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагуудад сонгон суралцах хэлбэрээр олгож, чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Албан бус боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсрол

23. Нийт иргэдэд хүний эрхийн албан бус боловсрол олгох ажлыг төрийн болон төрийн бус байгууллагаас олон улсын байгууллагуудтай хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд зохион байгуулж байна. Түүнчлэн, энэ ажилд хэвлэл, мэдээллийн байгууллагууд идэвхтэй оролцож байна.

24. 2005 оноос эхлэн Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх байгууллагад хүний эрхийг хангах салбар хороод байгуулагдан ажиллаж байна. Эдгээр хороодын үйл ажиллагааны гол чиглэл нь байгууллагынхаа ажилтан, албан хаагчдын хүний эрхийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах явдал юм. Иймд төрийн албан хаагчдын хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, иргэдийн эрх, эрх чөлөөг хүндэтгэн харьцах хандлага төлөвшүүлэх үүргээ гүйцэтгэхэд нь эдгээр салбар хороодыг мэргэшил, арга зүй, санхүү, нөөцөөр дэмжих шаардлагатай байна. Түүнчлэн, хүний эрхийг хангах салбар хороодыг тогтвортой ажиллах нөхцөл бололцоогоор хангах улмаар төрийн албан хаагчдад хүний эрхийн албан бус боловсрол олгох түшиц нэгж болгон хөгжүүлэхэд анхаарах нь зүйтэй байна.

25. Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.5-д заасны дагуу Комисс нь хүний эрхийн

боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг. Түүнчлэн хүний эрхийн сургалт, сурталчилгааны ажлыг бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг хамруулан зохион байгуулж, 2001-2006 оны хооронд 18.0 мянга орчим оролцогчдод 2.1 мянга гаруй цагийн хүний эрхийн сургалтыг явуулсан ба телевиз, радиогийн 70 гаруй бүтээл, 40 орчим ном товхимол, гарын авлагыг хэвлүүлэн нийтэд хүртээл болгосон байна. Энэ хугацаанд 21 аймаг тус бүрд 2-3 удаа хүний эрхийн нээлттэй өдөрлөгийг зохион байгуулжээ. Комиссын хүний эрхийн мэдээлэл лавлагааны болон хүний эрхийн сургалт, сурталчилгааны төвүүд хүний эрхийн боловсролыг дэмжихэд бодит хувь нэмрээ оруулж байна. Эдгээр ажлуудын ихэнхийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Канад Сан, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, Шведийн Хөгжлийн Агентлаг зэрэг донор байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэй хийж гүйцэтгэсэн юм. Хүний эрхийн боловсролын өргөн хүрээтэй үйл ажиллагаа зохион байгуулахад төсөвт тусгагдсан 1.5-2.8 сая төгрөг хангалтгүй байна. Иймд Комиссын хүний эрхийн боловсрол, сурталчилгааны төсвийг нэмж, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөл бололцоог хангаж өгөх шаардлагатай байна.

26. Хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэхэд иргэний нийгмийн байгууллагууд ихээхэн хувь нэмэр оруулж байна. 2007 оны байдлаар Хууль Зүй, Дотоод Хэргийн Яаманд 4200 гаруй төрийн бус байгууллага бүртгэгдсэнээс хүний эрхийн чиглэлээр ажилладаг 257²⁶ байгууллага байна. Түүнчлэн, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевизийг оролцуулаад нийт 16 телевиз, 1604 өдөр тутмын болон чөлөөт сонин, 490 сэтгүүл, 226 радио ажиллаж байна. Эдгээр байгууллага нь иргэдийн хүний эрхийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх асар их нөөц, бололцоо мөн. Иргэний нийгмийн байгууллагуудаас хүний эрхийн боловсролын чиглэлээр зохион байгуулж байгаа ажлыг уялдуулан зохицуулах, мэдээллээр хангах зэргээр дэмжлэг тусалцаа үзүүлэх шаардлагатай байна.

²⁶ Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамны Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын мэдээлэл, 2007 он

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн талаарх ээлжит 6 дахь илтгэлтэй холбогдуулан Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2-т заасны дагуу дараах санал, зөвлөмжийг гаргаж байна.

Нэг. Цэргийн албан хаагчид эрх, эрх чөлөөгөө эдлэх нөхцөл, бололцоог сайжруулах, тэдний халдашгүй дархан байх эрхийг нь зөрчиж буй хууль бус үйлдлийг таслан зогсоохын тулд:

1. Хугацаат цэргийн албан хаагчдыг дарамтлах, айлган сүрдүүлэх, мөнгө, эд зүйл шаардах, хувийн ажлаа хийлгэх зэргээр хууль бус харьцдаг зөрчлийг таслан зогсооход чиглэсэн удирдлага, зохион байгуулалт, хяналт шалгалтын үр дүнтэй тогтолцоог бий болгох;
2. Цэргийн албан хаагчдад сахилгын шийтгэл оногдуулахтай холбогдсон дүрэм, журмууд болон сахилгын хорих байрны стандартыг хүний эрхийн зарчим, шаардлагад нийцүүлэн өөрчилж, цэргийн албан хаагчдыг тусгаарлан саатуулах шийтгэлийг прокурорын байнгын хяналтанд гүйцэтгэдэг дадлыг хэвшүүлэх;
3. Батлан Хамгаалахын Их Сургууль, Хилийн Цэргийн Дээд Сургууль болон цэргийн албан хаагчдад зориулан зохион байгуулагддаг сургалтын төлөвлөгөөнд хүний эрхийн боловсролын чиглэлээр тусгай хичээл оруулж байх;
4. Цэргийн байгууллагын барилга байгууламжийн ашиглалт стандартад нийцэж байгаа эсэхийг шалган тогтоох нэгдсэн үзлэг зохион байгуулж, цэргийн албан хаагчдын ажиллах, амьдрах нөхцөл байдлыг сайжруулах талаар дэс дараатай арга хэмжээ авах;
5. Цэргийн албан хаагчдыг чанартай, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол, хүнс, хувцас, хэрэгслээр хангахад онцгой анхаарч, тэдгээрийн нийлүүлэлт, түгээлтэд тавих хяналтыг сайжруулах; Цэргийн хоол хүнс, хувцасны норм, нормативыг

мэргэжлийн хяналтын байгууллагаар шинэчлэн тогтоолгож, мөрдөх;

6. Цэргийн анги, байгууллагад цэргийн албан хаагчид албаны бэлтгэл сургуулилтыг хангахаас гадна хөгжих, сурч боловсрох, биеийн тамир, спортоор хичээллэх, амралт, чөлөөт цагаа үр өгөөжтэй өнгөрүүлэх боломжтой орчныг бүрдүүлэхэд шаардагдах материаллаг нөхцлийг бий болгоход дэмжлэг туслалцаа үзүүлэх;
7. Цэргийн албан хаагчдын цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн хамгааллыг сайжруулах, ялангуяа, алслагдсан хөдөө, орон нутагт ажиллаж буй цэргийн албан хаагчид хот суурин газарт үл хөдлөх эд хөрөнгө эзэмших боломжийг нэмэгдүүлэх, тэдний гэр бүлийн гишүүдийн эрхээ эдлэх боломж нөхцлийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах;
8. Цэргийн байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажиллагсдын үйлдвэрчний эвлэлийн байгууллагыг үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах.

Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэгш боломж олгох, тэдэнд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн иргэний, улс төрийн, эдийн засгийн болон соёлын бүхий л эрх, эрх чөлөөгөө бусдын адил эдлэх нөхцлийг бий болгоход чиглэгдсэн, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны А/61/611 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын конвенци”-ийг соёрхон батлах асуудлыг судлан шийдвэрлэх;
2. Нэр томъёоны хэт ерөнхий байдлаас үүдэн гарч буй сөрөг үр дагаврыг арилгахын тулд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэсэн тодорхойлолтыг тодорхой, ойлгомжтой болгон өөрчлөх;
3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан болон Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны боловсруулсан салбарын хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн

- төслийг хэлэлцэхдээ Хүний Эрхийн Үндэсний Комиссын энэхүү илтгэлд тусгагдсан асуудлуудыг харгалзан үзэх;
4. Энэхүү илтгэлд дурдсан асуудлуудыг харгалзан Нийгмийн халамжийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиудын зарим зүйл заалт болон Шагнал, урамшууллын хэмжээ тогтоох тухай Засгийн газрын 208 дугаар тогтоол (2005), Мэргэжлээс шалтгаалах болон энгийн өвчин, гэмтлийн жагсаалт (1997), Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм (1994), Амбулатори, поликлиникээр үнэ төлбөргүй эмчлэх өвчин, түүнд хэрэглэх эмийн жагсаалт (2003) зэрэг хуульчилсан актуудыг аль болох хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрхээ эдлэх тэгш боломжоор хангасан, тэдний эрх зүйн байдлыг дээрдүүлсэн байхаар өөрчлөх;
 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээнд нийцсэн барилга, талбай, зам, гүүр, харилцаа холбоо, ажлын байр, тээврийн хэрэгсэл зэрэг нэн шаардлагатай дэд бүтэц, байгууламжийн стандартыг боловсруулж, хэрэгжүүлэх;
 6. Аливаа хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг батлахдаа тэдгээрийг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц санхүүжилтийн асуудал, механизмыг цогцоор нь шийдвэрлэж байх;
 7. 2010 онд Үндэсний Статистикийн Газраас явуулах хүн амын нэгдсэн тооллоготой хамтатган хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар нарийн тоо баримт гаргаж, төрийн бодлогыг зохистой хэрэгжүүлэх, үйлчилгээг үр дүнтэй хүргэх, үр дүнг нь бодитойгоор үнэлэх нөхцөл бололцоог бий болгох;
 8. Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв, Сэргээн Заслын Үндэсний Төв, Тусгай Хэрэгцээт Боловсролын Байгууллагууд зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулагдсан байгууллагуудад онцгойлон анхаарал хандуулж, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоог хангах талаар арга хэмжээ авах;
 9. Сэтгэцийн өвчтэй хүмүүст зориулсан тусгай асрамжийн газар бий болгох;
 10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд

хөтөлбөр болон 2006 оны Хүний эрхийн байгууллагуудын үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих.

Гурав. Албан ба албан бус боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсрол олгох ажлын чанар, үр дүнг сайжруулах үүднээс:

1. Хүний эрхийн боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл байдалд цогц үнэлгээ хийсний үндсэн дээр Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт заасны дагуу “Хүний эрхийн боловсрол олгох дэд хөтөлбөр”-ийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх; Дэд хөтөлбөрийг энэ чиглэлээр гарсан олон улсын баримт бичиг, хөтөлбөрүүдэд нийцүүлэн боловсруулах;
2. Албан ба албан бус боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсрол олгох сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний хувилбаруудыг боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжөөр хангах;
3. Эрх зүйч, төрийн захиргааны болон цэргийн албан хаагчид, эмч, багш бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хүний эрхийн боловсрол олгох хичээлийг заавал судалдаг болгох; Эмчлэх, багшлах зэрэг эрх олгох шалгуурт хүний эрхийн мэдлэг, хандлагыг тодорхойлох үзүүлэлтүүдийг тусгах;
4. Хүний эрхийн сургалтын гарын авлага, материал бусад хэрэглэгдэхүүнийг боловсруулах, сургагч багш нарыг бэлтгэх, тэдний мэргэжил, мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх ажлыг нэгдсэн бодлогоор зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
5. Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгох талаарх иргэний нийгмийн байгууллагуудын санаачлагыг дэмжих, урамшуулах, хамтран ажиллах.



Mongolia

НҮБХХ нь мэдлэг, туршлага, нөөцийг холбож, улс орнуудын өөрчлөлтийг олон нийтэд хүргэх замаар илүү сайн сайхан амьдралыг цогцлон байгуулахад хүмүүст туслах зорилго бүхий НҮБ-ын дэлхий нийтийн хөгжлийн сүлжээ юм.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

Улаанбаатар хот, Эрх чөлөөний талбай,
Засгийн газрын XI байр, 5 дугаар давхар

Утас: 262589, 262902

Факс: 976-11-262752

Цахим шуудан: contact@mn-nhrc.org

НН.МН
СҮДАЛГААНЫ САН